

---

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН  
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

---



2024 оны 01 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

## ГАРЧИГ

1. ОРШИЛ.....	3
2. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	5
2.1. Төсвийн хүрээний мэдэгдэлд өгсөн зөвлөмж .....	5
2.2. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд өгсөн зөвлөмж.....	6
2.3. Төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал.....	7
2.4. Төсвийн тодотголын төсөлд өгсөн зөвлөмж.....	7
2.5. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд өгсөн зөвлөмж.....	8
2.6. Судалгааны ажил .....	9
3. ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	10
3.1. Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх төслийн хэрэгжилт.....	10
3.2. Албан бичгээр бусад байгууллагуудтай харилцсан байдал .....	10
3.3. Олон улсын байгууллагатай хамтран ажилласан байдал .....	10
3.4. Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дэмжлэг .....	11
4. ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦСАН БАЙДАЛ .....	11
5. ЗӨВЛӨЛИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	12
ХАВСРАЛТУУД .....	13
Хавсралт 1. ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын динамик (хувиар).....	13
Хавсралт 2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт.....	13
Хавсралт 3. Төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд өгсөн зөвлөмж .....	14
Хавсралт 4. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд өгсөн зөвлөмж .....	26
Хавсралт 5. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал .....	29
Хавсралт 6. Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголд өгсөн зөвлөмж.....	30
Хавсралт 7. Төсвийн байнгын хорооны хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлээс .....	36
Хавсралт 8. Ярилцлагын тэмдэглэл .....	43

## 1. ОРШИЛ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилготойгоор 2010 онд УИХ-аар баталснаас хойш төрийн мэдэлд Хүний хөгжлийн сан, Тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан хэлбэрээр хуримтлал үүсгэх оролдлого хийж байна. Гэсэн хэдий ч тодорхой шалтгааны улмаас эдгээр санд хуримтлагдсан хөрөнгийг зарцуулж, төсвийн алдагдал (Хавсралт 1)-ыг нөхөхөд зориулан төсвийн орлого, зарлагын бүрэлдэхүүн болгох эрх зүйн зохицуулалтыг хийлээ.

2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар Төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдэл 1,231.4 тэрбум төгрөг, Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 2,788.3 тэрбум төгрөг тус тус байсан бол Монгол Улсын 2024 оны төсөвт Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлагдах хөрөнгийн хэмжээг 513.7 тэрбум төгрөг байхаар, Ирээдүйн өв санд хуримтлагдах хэмжээг 1,353.3 тэрбум байхаар тус тус тусгажээ.

Төсвийг ашигтай байлгах, давагдашгүй хүчин зүйлийн улмаас төсвийн алдагдлыг ДНБ-ий хоёр хувиас, харин Засгийн газрын өрийг ДНБ-ий 40 хувиас хэтрүүлэхгүй байлгах Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан төсвийн тусгай шаардлагуудыг олон удаа өөрчилж (Хавсралт 2), бодит хэрэг дээрээ суурь шаардлагуудыг хангаж чадсангүй.

Монгол Улсын эрх зүйн болон улс төрийн нөхцөл байдал, баялгийн ашиглалтын төлөв, иргэдийн ихэнх нь хуримтлалгүй байгаа байдал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ)-ийн 3 жилийн ажлын туршлага, олон улсын шилдэг туршлага зэргийг бодолцон баялгийн өгөөжөөс үүсэх хуримтлал УИХ, Засгийн газрын мэдэлд байхын зэрэгцээ давхар иргэдийн мэдэлд хуримтлал үүсгэн байлгах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн юм.

Энэхүү дүгнэлтэд үндэслэн баялгаа эрчимтэй ашиглаж буй өнөө үед ирээдүй үеийнхэндээ чиглэсэн хуримтлал бий болгох оновчтой арга замыг олж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хуримтлал үүсгэх суурь зорилтыг хангах явдал бол хойшлуулшгүй зорилт гэж үзэж даатгуулагчдын өөрсдийнх нь төлдөг нийгмийн даатгалын хэсгээс тэтгэврийн даатгалын шимтгэлийг нь хадгаламж хэлбэрээр тэдний мэдэлд үлдээх замаар ийм хуримтлалыг бий болгох саналыг ТТБЗ-өөс удаа дараа гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Чингэхдээ энэхүү дүгнэлт, саналыг хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу ТТБЗ нь УИХ-ын Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэхийн зэрэгцээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэж ажиллахыг зорилоо.

Үүний үр дүнд хөдөлмөр эрхэлж буй иргэн (даатгуулагч) бүрийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг тэтгэврийн нөөц санд хуримтлуулах эхлэл 2024 оны төсвөөр (2024 онд 389.4 тэрбум төгрөгөөр тэтгэврийн нөөц санг мөнгөжүүлэхээр тусгасан) тавигдсан нь холыг харсан үлдэцтэй бодлого гэж үзэж байна. Үүнийг дэс дараатай нэмэгдүүлэх үүргийг УИХ-аас Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн дагуу авч ажиллахыг Засгийн газарт үүрэг болгох нь чухал юм. Мөн энэ нь шинээр ажиллах ТТБЗ-ийн үндсэн үүрэг байх болно. Нөгөө талаар *Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн гол санаа бол баялгийн өгөөжийг одоо ба ирээдүй үеийнхэнд тэгш хуваарилах явдал билээ. Өөрөөр хэлбэл, баялгийн өгөөжийг бүгдийг нь төсвөөр болон бусад санхүүгийн хэрэгслээр дамжуулан зөвхөн өнөө үеийнхэн хэрэглэх нь Үндсэн хууль зөрчсөн хэрэг болох юм.*

2024 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжид 1,562.9 тэрбум төгрөг олгохоор төлөвлөсөн. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хүүхдийн мөнгийг эхлээд халамжийн хуулийн дагуу зорилтот бүлгийн хүүхдүүдэд олгож, үлдсэн мөнгийг бүх хүүхдэд тэгш хуваарилан хуримтлал хэлбэрээр олгох нь хуульд бүрэн нийцнэ гэж үзэж, энэ талаарх санал, зөвлөмжийг Улсын Их Хурлын дарга, Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн.

Монгол Улс баялгаа эрчимтэй ашиглах үедээ иргэддээ хуримтлал үүсгэх, төсвөө алдагдалгүй болгоход илүүтэй анхаарч, харин өр зээл тавихаа зогсоох шаардлагатай. Үүний үр дүнд өндөр настан, хөдөлмөр эрхлэгч, хүүхдийн ирээдүйг хамгаалах шударга зарчим тогтож, нийгэмд дундаж давхарга давамгайлж, эдийн засгаа урт, дунд хугацаанд хөгжүүлэх дотоод эх үүсвэртэй болох юм.

Энэ нь “Алсын хараа-2050”, Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан томоохон төсөл, арга хэмжээг дунд хугацаанд дотоодын эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжийг бүрдүүлж, гадаад эх үүсвэрийн хөрөнгө, төсөв болон төлбөрийн тэнцэл дээр их ачаалал үүсгэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх давуу талтай болно.

Монгол Улсын коксжих нүүрсний экспорт нэмэгдэж 60 сая тонныг давсан, Оюутолгойн гүний уурхай ашиглалтад орж, ойрын жилүүдэд Монгол Улс нийтдээ зэсийн баяжмалын экспортыг 3 дахин нэмэгдүүлэх боломж бүрдэж байна. Нөөц ихтэй энэхүү 2 баялаг бол нэг хэсэгтээ Монгол Улсын хөгжлийн хөдөлгүүр, төсвийн болон валютын орлогын дийлэнхийг бүрдүүлэх төлөвтэй байна. Энэхүү баялгаа их хэмжээгээр ашиглах “цонх” үедээ хөгжлийн дараагийн үе шатанд хөтлөх механизм бол тэтгэврийн болон хүүхдийн хуримтлал мөн гэдэг үзэл санааг ТТБЗ барьж байна. Үүнийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль ч шаардаж байгаа юм.

Дээрх хуримтлалыг дэмжих суурь үзүүлэлт болох валютын ханш, инфляцыг тогтвортой түвшинд байлгах талаар төр, засгаас тодорхой анхаарч, төсвийг алдагдалгүй батлах, төлбөрийн тэнцлийг алдагдалгүй байлгах, гадаад зээлийг үе шаттайгаар бууруулах гэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр дахь дүгнэлт бол хот, аймаг, сумын түвшинд төсвийн эрх мэдэл огт байхгүй болсон бөгөөд орон нутгийн бүх төсөв захирагчдын орон тоо яг төвдөө данхайсан шиг хөдөө, орон нутагтаа хэрээс хэтэрч том болсон ч цалин авахаас өөр эрхгүй болсныг судалгааны үр дүн харуулж байгаа юм (Хамгийн сүүлчийн судалгааны үр дүнгээр хийсэн ярилцлагыг тайланд хавсаргав).

Гурав дахь зарчмын дүгнэлт бол ихэнх иргэд нам, төрийн ойрыг харсан амлалтад найдаж ажил хийх сонирхолгүй болсон, импортын бараа, үйлчилгээний үнийн зөрүү дээр ажилладаг бизнес голлох болсон байна. Гэтэл ажлын байрыг дэмжих замаар л төсвийн тогтвортой байдал хангагдана.

Дөрөв дэх дүгнэлт бол ойрын 5 жилийн эдийн засаг, таваарын бүтээгдэхүүний зах зээлийн нааштай байдлыг урьдын адил халамжийн амлалтаар удирдаж огт болохгүй бөгөөд дотоод хуримтлалыг үүсгэж, валютын нөөцийг тултал нь нэмэгдүүлэх нь амин чухал юм.

Дээр дурдсан чиглэл, зорилтыг хэрэгжүүлж ажиллах нь шинээр байгуулагдах ТТБЗ-ийн үндсэн үүрэг байх болно.

## 2. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл өөрийн үйл ажиллагааны хүрээнд тайлант хугацаанд нийт 5 удаа хуралдаж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16<sup>1</sup>.1-д тусгагдсан бүрэн эрхийн хүрээнд дараах хуулийн төсөлд хараат бус, бие даасан үнэлгээ, дүгнэлт гаргах чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллалаа.

### 2.1. Төсвийн хүрээний мэдэгдэлд өгсөн зөвлөмж

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй Төсвийн тогтвортой байдлын зөвлөл танилцаад зөвлөмж (Хавсралт 3) гарган 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 03 дугаар албан бичгээр Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд хүргүүлж, Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан (Хавсралт 7) юм.

Зөвлөмжийн хэсгээс товч дурдвал:

1. Баялгаа эрчимтэй ашиглаж буй өнөө үед ирээдүй үеийнхэндээ чиглэсэн хуримтлал бий болгох оновчтой арга замыг олж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн суурь зорилтыг хангахын тулд хуримтлал үүсгэх явдал бол хойшлуулшгүй зорилт болно. Ийм хуримтлалыг даатгуулагчдын өөрсдийнх нь төлдөг нийгмийн даатгалын хэсгээс тэтгэврийн даатгалын шимтгэлийг хадгаламж хэлбэрээр тэдний мэдэлд үлдээх замаар бий болгох саналыг тавьж байна. Төр, засгийн мэдэлд хуримтлал үүсгэж чадахгүй гэдгийг хуримтлал үүсгэхийг оролдсон сүүлийн 18 жилийн үйл ажиллагаа харууллаа. Итгэл даахгүй, хүссэн үедээ хуульд өөрчлөлт оруулдаг нь ирээдүйг төсөөлөх боломжийг олгохгүй байна.

2. УИХ-аас хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах Үндсэн хуулиар олгогдсон онцгой эрхийн хүрээнд Төсвийн тогтвортой байдлын тухай 2010 оны хуульд 13 удаа өөрчлөлт оруулсан. Мөн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг жил бүрийн 5 дугаар сард хуульчлан тогтоогоод дараа жилийн төсөв батлах үедээ өөрчилдөг явдал үргэлжилсээр байна. Монгол Улс 2012-2022 оны хооронд 10 удаа батлах ёстой дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг нийт 30 удаа Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан. Иймд Төсвийн тогтвортой байдлын тухай 2010 оны хуульд заасан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, төсвийн тоо, баримтуудыг ангилж, заавал мөрдөх, эсвэл зорилт үүрэг болгох, эсвэл баримжаа үзүүлэлт хэлбэрээр ялгаж, олон улсын чиг хандлагын дагуу төсвийн хүрээний мэдэгдлээс илүүтэй дунд хугацааны зарлагын хүрээ, хязгаар болгон шинэчилж, төсөв захирагчдын үүрэг хариуцлага, эрхийг нэмэгдүүлэх асуудлыг судлах хэрэгтэй байна.

3. ТХМ-ийн төсөлд тусгагдсан 2024 оны дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 32.3 хувь, нийт зарлага 35.1 хувь байгаа нь өндөр хэвээр байна. Мөн 2025-2026 онуудад бага зэрэг бууруулахаар төсөөлсөн хэдий ч энэ нь олон улсын жишгээс өндөр хэвээр байна. Иймд дунд хугацааны төсвийн төсөөлөлдөө дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлагын хувийг буулгаж 28-30 хувьд хүргэж, хувийн хэвшлийн байгууллагуудад бизнес хийх орон зайг үлдээх нь төсвийг үр ашигтай зарцуулах, төсвийг алдагдалгүй батлах, эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг төсвийн бодлогоороо дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.

4. Төсвийн орлого 2022, 2023 оны уул, уурхайн бүтээгдэхүүний орлого, валютын ханшийн өсөлтөөс шалтгаалан нэмэгдэж байгаа ч эдгээр бүтээгдэхүүний үнэ буурсан үед орлогыг дагаж өссөн зардлын хэмжээг бууруулахад хүндрэл үүсэх эрсдэл нэмэгдсээр байна. Үүнээс сэргийлэхийн тулд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зардлын хязгаарыг салбарчлан тогтоосон шалгуур үзүүлэлт нэмэлтээр оруулах нь зүйтэй. ТТБЗ-өөс төсвийн

нийт зарлагыг дотоодын нийт бүтээгдэхүүний 28-30 хувиас ихгүй байхаар төсвийн төслийг боловсруулах нь зохимжтой гэсэн саналтай байна.

5. Төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг шийдвэрлэхдээ жижиг сум, суурины барилга барих, зам хашлага солих гэх мэтээс илүүтэйгээр Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд эдийн засгийн тэлэлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг шийдвэрлэхэд тэргүүн зэргийн ач холбогдол өгөх нь зүйтэй. Тухайлбал, Автозамын төслүүдийг эдийн засгийн өгөөж, бүс нутгийн онцлогт тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тээвэр, ачаа эргэлт, үйлдвэрлэлийн бүсийн гол замуудыг тэргүүн зорилт болгож, онцлогт нь тохирсон чанартай зам барих нь урт хугацаандаа тээврийн зардлыг бууруулах, замын арчилгааны зардлыг багасгах, цаашлаад олон улсын транзит тээврийг хөгжүүлэх зэргээр урт, дунд хугацааны Монгол Улсын хөгжлийн бодлоготой уялдуулах боломжтой.

## **2.2. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд өгсөн зөвлөмж**

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай төсөлтэй Төсвийн тогтвортой байдлын зөвлөл танилцаад зөвлөмж (Хавсралт 4) гарган Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн.

Зөвлөмжийн хэсгээс дурдвал:

1. 2022 онд манай улсын төмөр замын сүлжээний урт 2,964.9 км болж 40 хувиар нэмэгдэв. Тавантолгой-Гашуунсухайт, Зүүнбаян-Ханги, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 876.4 км төмөр замын бүтээн байгуулалтын барилгын ажил дуусаж, төмөр замаар хийх экспортын гурван гарцтай болсон. Гэхдээ хил холболтын төмөр замын ажил хийгдээгүйн улмаас шинэ төмөр замын гарцуудаа бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна. Иймд эдгээр мухар төмөр замуудыг Бүгд Найрамдах Хятад Ард улсын төмөр замтай яаралтай 2024 онд багтаан холбовол бид нүүрсний экспортоо нэмэгдүүлж, үнэтэй борлуулах, өрсөлдөх боломж бүрдэнэ. Иймд энэ ондоо багтааж дуусгахад улс төр, дипломат, хөрөнгө мөнгөний бүхий л хүчин чадлаа гаргах шаардлагатай байна.

Цаашид аливаа бүтээн байгуулалтын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах нь эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх суурь нөхцөл болно. Иймээс өндөр өртөг бүхий ижил төстэй төслүүдийг нэгэн зэрэг эхлүүлэх бус, ач холбогдлоор нь эрэмбэлэн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн гүйцэтгэж, үйл ажиллагаа нь жигдэрсний дараа шат дараатай хүчин чадлыг нэмэгдүүлж, төрөлжүүлэх нь төсөв болон валютын нөөцөд ирэх ачааллыг бууруулах, дотоодын нөөцийн хүчин чадлыг зохистой ашиглах зэрэг эерэг үр дагавартай юм.

2. Монгол Улсын цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээ 2022 онд 10.3 тэрбум кВт.ц болж өмнөх оноос 5.8 хувиар буюу 564.3 сая кВт.ц-аар нэмэгдсэн байна. Нийт хэрэглээний 79.1 хувийг буюу 8.18 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүчийг дотоодын үйлдвэрлэлээр, 20.9 хувийг буюу 2.16 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүчийг импортоор авч хангажээ. Импортын эрчим хүчний төлбөрт 182.3 сая ам.доллар зарцуулсан бөгөөд энэ нь өмнөх оны гүйцэтгэл 160.2 сая ам.доллараас 22 сая ам.доллар буюу 13.8 хувиар өссөн үзүүлэлт юм. Хэдийгээр Монгол Улсын Засгийн газраас цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлж байгаа ч энэ нь хэрэглээний өсөлтөөс давахгүй байна. Иймд Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Эрчим хүчний зорилт болон хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийг сайжруулж, 2024 онд эрчим хүчний хүчин чадлыг доод тал нь 20-оос доошгүй хувиар нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Цахилгаан эрчим хүчний импортын хэрэглээ нь олон жил үргэлжилж, ялангуяа говийн үйлдвэрлэлийн бүсүүдэд эрчим хүчний эх үүсвэр нэн шаардлагатай байгаа ч төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт удааширсан хэвээр байна. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд хэд хэдэн эрчим хүчний төслүүд, өргөтгөлийн ажлуудыг тусгасан байгаа хэдий ч ойрын хугацаанд ашиглалтад орох томоохон хүчин чадал бүхий эрчим хүчний үйлдвэрүүд байхгүй байна. Түүнчлэн эрчим хүчний салбарт олгож буй татаасын өгөөж тэгш бус байдгаас гадна эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлж, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөтэй байдаг. Суурь салбарын үнийг барьж, хөрөнгө оруулалтын сонирхлыг бууруулдаг гажиг тогтолцооноос салж, үнэ тариф, цалин хөлсний томоохон өөрчлөлт энэ салбарт хэрэгтэй.

### **2.3. Төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал**

2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Улсын Их Хурлын 32 гишүүний боловсруулж, өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах төслийн талаар ТТБЗ-ийн хурлаар хэлэлцэж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяагийг дэвшүүлсэн санал (Хавсралт 5)-ыг дэмжиж Төсвийн байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

### **2.4. Төсвийн тодотголын төсөлд өгсөн зөвлөмж**

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй Төсвийн тогтвортой байдлын Зөвлөл танилцаад зөвлөмж (Хавсралт 6) гарган 2022 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Зөвлөмжийн хэсгээс товч дурдвал:

1. Хүүхдийн мөнгийг бүх хүүхдэд олгохын зэрэгцээ цаашдаа халамжийн хуулийн хүрээнд эмзэг бүлэгт нь олгох асуудлыг хэвээр нь үлдээх шаардлагатай. Хэрэв эдийн засаг хүндрэх тохиолдолд бүх хүүхдэд олгох бус зайлшгүй шаардлагатай хүүхдүүд олгох нөхцөлийг тооцох. Хүүхдийн мөнгийг Ирээдүйн өв сангаас зарцуулахаар тооцсон бөгөөд Ирээдүйн өв сангийн мөнгийг хуримтлал болгож байх хуулийн заалттай. Иймд хүүхдийн мөнгийг бүхэлд нь мөнгөн хадгаламж хэлбэрээр хуримтлал болгож, түүнээс халамжийн хуулийн шаардлага, нөхцөлийн дагуу зарцуулах эрхийг нь эцэг эхэд нь үлдээх, хүүхдийн мөнгийг хуримтлал болгох бодлого барих шаардлагатай.

2. Тэтгэврийн зөрүүг багасгаж, тэтгэврийг нэмэгдүүлэх нь чухал ч гэсэн цаашдаа тэтгэврийн сангийн дампуурах эрсдэлийг багасгах, дэлхий нийтийн сүүлийн үеийн хандлагад нийцсэн шинэчлэл хийх үүднээс тэтгэврийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх хөшүүрэг бий болгох, ахмадуудад тэтгэврийн нэмэгдэл орлого бүрдүүлэх тодорхой бодлого гаргах шаардлагатай. Үүний тулд өндөр насны тэтгэврийн даатгалаас даатгуулагчийн өөрийн төлж байгаа хэсгийг мөнгөн хадгаламж хэлбэрээр хуримтлал болгох нь зүйтэй юм.

3. Дээр дурдсан хүүхдийн мөнгө болон тэтгэврийн даатгалаас хуримтлал бий болсноор Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан томоохон төсөл, арга хэмжээнүүдийг дунд хугацаанд дотоодын эх үүсвэрээс санхүүжүүлэх боломж бүрдэж, гадаад эх үүсвэрийн хөрөнгө, төсөв болон төлбөрийн тэнцэл дээр их ачаалал үүсгэж байгаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх давуу талтай юм. Мөн төсөв болон төлбөрийн тэнцэл дээр өндөр ачаалал үүсгэж байгаа зарим гадаадын хөрөнгө оруулалтыг бодлогын түвшинд эргэж харах шаардлагатай байна. Ажлын байр, нэмүү өртөг бий болгосон хөрөнгө оруулалтыг татвараас чөлөөлж, харин байгалийн баялгийг ухаж авдаг, эсвэл ууж идэх, наргиж наадах

чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг (баар цэнгээний газар, хоолны газар) салбарын хөрөнгө оруулалтад зарчмын өөрчлөлт хийх хэрэгтэй байна.

4. Хуримтлал үүсгэснээр Үндсэн хуулийн гол өөрчлөлт болсон баялгийн өгөөжийг өнөө ба ирээдүй үедээ тэгш хуваарилна гэсэн зарчимтай нийцэхийн зэрэгцээ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үндсэн зорилго болсон хуримтлал бий болгох гэсэн зарчимтай нийцэх юм. **Баялгаа эрчимтэй ашиглах үедээ эдийн засгийг алс ирээдүйд хөтлөгчөө одооноос олж бэлдэж авахгүй бол нөөц дуусах болно.**

5. Монгол Улсад ажилчин хүний хөдөлмөрийн **үнэлэмж** маш бага байгаа учир чадварлаг боловсон хүчин гадаадад гарч улс орон чадварлаг болсон хүчнээр дутах эрсдэл их байна. Тийм учраас төрийн албан хаагчдын чадварлаг 10 хүртэлх хувьд нь цалинг тогтоосон хэмжээнээс нэмж олгох боломжийг төсвийн байгууллага болон улсын үйлдвэрийн газруудад хуулиар нээж өгөх. Энэ мөнгийг өөрийн орлого болон ноогдол ашгаас нь тооцож олгохоор журамлах, хуульчлах хэрэгтэй болно.

## 2.5. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд өгсөн зөвлөмж

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16<sup>1</sup>.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах зарим хуулийн төсөлд 16 зүйл бүхий зөвлөмжийг гаргаж, 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Төсвийн байнгын хороонд хүргүүлж, Улсын Их Хурлын гишүүдэд тараасан.

Зөвлөмжийн хэсгээс товч дурдвал:

1. Төлбөрийн тэнцлийг сайжруулах, татвар ногдох орлогыг нэмэгдүүлэх, зардал хэмнэхэд онцгой ач холбогдолтой төслүүд (тухайлбал, өмнийн говийн төмөр замын бүтээн байгуулалтуудыг дуусгаж, Хятадын боомтуудтай холбох, төмөр замын хүчин чадал хөдлөх бүрэлдэхүүн, цахилгаан, дулааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төсвийн болон төрийн өмчит компаниудын, түүнчлэн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн хэрэгжүүлж буй төслүүд)-д тавих УИХ-ын хяналтыг чангатгаж, төсвийн ба валютын орлогын тогтвортой байдлыг хангах, валютыг хэмнэх;

2. Төсвийн нийт зарлага ДНБ-ий 37.0 хувийг эзэлж буй бөгөөд энэ нь эдийн засаг дахь төрийн үүрэг, оролцоо өндөр байгааг харуулж байна. Төрийн ихэнх байгууллагууд нь ашгийн бус, эдийн засгийн үржүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэггүй тул дийлэнх зардал нь хэрэглээ болж байна. Иймд 2024 онд ДНБ-д эзлэх тэнцвэржүүлсэн төсвийн алдагдлыг 2 хувиас хэтрүүлэхгүйгээр, суурь төсвийг алдагдалгүйгээр тооцож, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх, эдийн засаг, санхүүгийн нөөцийг хувийн секторт чиглүүлэх орон зайг үүсгэхийн тулд ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хэмжээг бууруулах шаардлагатай. Энэ нь төрийн сангийн мөнгийг хуримтлал болгож, мөнгөний бодлогод орон зай үүсгэснээр хувийн хэвшил хөгжин тэлэх орон зайг бий болгох юм.

3. Монгол Улсын Засгийн газрын нийт өрийн үлдэгдлийн 92.7 хувийг гадаад зээл эзэлж, мөнгөжилт буюу хуримтлалыг илэрхийлдэг M2 болон дотоодын нийт бүтээгдэхүүний харьцааны үзүүлэлт 2022 онд 56.1<sup>1</sup> хувь байхад Англи, Франц улсуудын дундаж 160 гаруй хувь, Японд 283.2, Хятадад 220.2, дунджаас доогуур орлоготой дэлхийн улс орнуудын дундаж 80<sup>2</sup> орчим хувьтай байгаа нь манай улс дотоодын хуримтлал бага,

<sup>1</sup> Монголбанк

<sup>2</sup> <https://data.worldbank.org/indicator/FM.LBL.BMNY.GD.ZS?locations=MN>



Засгийн газраас иргэдийн хуримтлал, мөнгөн орлогыг өсгөх, улсын нийт өрийн ачаалал даах чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засгийн бүтцийг бий болгох, төсөв, мөнгөний бодлогыг тууштай авч хэрэгжүүлэх бодит хэрэгцээ байгааг харуулж байна.

Иймд хүүхдийн мөнгийг эхлээд халамжийн хуулийн дагуу зорилтот бүлгийн хүүхдүүдэд олгож, үлдсэн мөнгийг бүх хүүхдэд тэгш хуваарилан хуримтлал хэлбэрээр олгох нь хуульд бүрэн нийцнэ гэж үзэж байна. Ингэснээр хүүхдийн мөнгө болон тэтгэврийн даатгалаас хуримтлал бий болно. Энэ нь “Алсын хараа-2050”, Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан томоохон төсөл, арга хэмжээг дунд хугацаанд дотоодын эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжийг бүрдүүлж, гадаад эх үүсвэрийн хөрөнгө, төсөв болон төлбөрийн тэнцэл дээр их ачаалал үүсгэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх давуу талтай юм.

4. Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2024 онд 5,038.0 сая ам.доллар болж нэмэгдэхээр тооцсон байгаа энэ үед Тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сангуудын үлдэгдлийн тодорхой хэсгээр валют худалдан авч, олон улсын санхүүгийн зах зээл дээр байршуулж, арвижуулах арга хэмжээ авах. Ингэснээр Монголбанк ганцаараа мөнгө гаргах замаар валютын нөөцийг өсгөж, инфляцыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлдгийг ямар нэгэн хэмжээгээр багасгах юм. Энэ нь бий болсон хуримтлалаараа валют худалдан авдаг олон улсын жишигт нийцнэ.

5. Олон төслийг нэгэн зэрэг эхлүүлж, жил дамнан бүтээн байгуулах бус, цөөн тооны ач холбогдол өндөртэй төслүүдэд илүү ач холбогдол өгч богино хугацаанд эдийн засгийн эргэлтэд оруулахад анхаарах нь тухайн төслийн өртөг жил бүр өсөх, үйлдвэрлэлийн явц удааширч алдагдсан боломжийн өртөг нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөг бууруулах боломжтой.

## **2.6. Судалгааны ажил**

1. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын иргэн Я.Онгойбортой “Төсвийн тогтвортой байдлыг хангахад орон нутгийн төр, захиргааны байгууллагын үүрэг, эрх хэмжээ, төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийн хэрэгжилтийг судлах” судалгааны гэрээг байгуулсан. Судалгааны тайлан, судлаачтай хийсэн ярилцлагаас үзэхэд орон нутгийн зарим байгууллагын албан тушаалтныг төв байгууллагаас нь томилдог, орон нутагт төвлөрч байгаа төсвийн ихэнх хэсгийг улсын төсөвт төвлөрүүлж байгаа нь орон нутгийн бие даасан байдлыг хангахад хүндрэл үүсгэж байгааг онцолжээ (Хавсралт 8).

2. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Монгол Улсын иргэн С.Бадралтай 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Төлбөрийн тэнцэл болон импорт” сэдэвт судалгааны гэрээг байгуулсан. Судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол Улсын эдийн засагт импорт асар их нөлөөтэй гэдэг нь харагдаж байна. Судалгааны хураангуйд дурдсанаар: сүүлийн 20 жилийн статистикаас үзэхэд импортын хэмжээ ДНБ-ий 70 орчим хувь (зарим үед, Оюутолгой, Тавантолгойн хөрөнгө оруулалт идэвхэжсэн үед нийт эдийн засгаас давна)-ийг эзэлж байна. Тухайлбал, 2022 онд ДНБ 17.1 тэрбум ам.доллар, импорт 12.1 тэрбум ам.доллар байна. Харин сүүлийн 10 жилийн статистикаас үзэхэд импортын гааль, НӨАТ, онцгой татвар бүгд нийлээд нэгдсэн төсвийн нийт орлогын 24-26 хувь орчим хувийг эзэлж байгааг харуулжээ. Нэгдсэн төсвийн орлого 2022 онд 18.5 их наяд төгрөг байгаагийн 4.6 их наяд төгрөг буюу 24.86 хувийг импортын татвар эзэлж байна.

### **3. ХАМТЫН АЖИЛЛАГАА**

#### **3.1. Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх төслийн хэрэгжилт**

Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх төслийн хэрэгжих хугацаа 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр дууссан бөгөөд энэхүү төсөл нь Зөвлөлийн үйл ажиллагаа, чадавхыг бэхжүүлэхэд олон талаас дэмжиж ажилласан. Төслийн шалгуур үзүүлэлтэд ТТБЗ-тэй холбоотой 2 үзүүлэлт байсан бөгөөд төслийн үр дүнд эдгээрийг бүрэн хангасан гэж дүгнэсэн. Үүнд:

1. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь тогтвортой үйл ажиллагаа явуулж, Засгийн газрын макро эдийн засаг болон төсвийн бодлогын боловсруулалтын ил тод байдал, оновчтой байдлыг дэмжихэд хараат бус төсвийн тайлан гаргадаг болсон байх;
2. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь үйл ажиллагааны журмаа боловсруулан хэрэгжүүлсэн байх.

#### **3.2. Албан бичгээр бусад байгууллагуудтай харилцсан байдал**

Тайлант хугацаанд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дараах 8 байгууллага, албан тушаалтанд нийт 25 албан бичгийг хүргүүлж ажиллалаа. Үүнд:

- Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх төсөл хэрэгжүүлэх нэгжид санал хүргүүлэх талаар (1 удаа);
- Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд Зөвлөлийн зөвлөмж, тайлан хүргүүлэх, хүүхдийн мөнгийг хуримтлал болгох талаар (6 удаа);
- Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд Зөвлөлийн зөвлөмж хүргүүлэх талаар (1 удаа);
- Монгол Улсын Сангийн яаманд зөвлөмж, дүн шинжилгээ, нэр хүргүүлэх тухай (3 удаа);
- Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад Зардал санхүүжүүлэх тухай (10 удаа);
- Засгийн газрын авто баазад Суудлын авто машин захиалах тухай (2 удаа);
- Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт Хүүхдийн мөнгийг хуримтлал болгох талаар (1 удаа);
- Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнд Хүүхдийн мөнгийг хуримтлал болгох талаар (1 удаа).

#### **3.3. Олон улсын байгууллагатай хамтран ажилласан байдал**

- Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр ОУВС-ийн суурин төлөөлөгчтэй уулзалт хийсэн бөгөөд уулзалтаар Баялгийн сан, эдийн засаг, нийгмийн бусад асуудлаар санал солилцсон.
- ОУВС-ийн Төсвийн газраас Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээг (Public Investment Management Assessment-PIMA) хийх зорилгоор техник туслалцааны ажлын хэсэг 6 дугаар сарын 19-нөөс 7 дугаар сарын 04-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо ажилласан. Ажлын хэсэг 6 дугаар сарын 21-ний өдөр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүд, УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн төлөөлөлтэй уулзаж улсын хөрөнгө оруулалт, өрийн менежментийн асуудлаар (Өрийн тогтвортой байдал, Төсвийн дүрмийн хэрэгжилт, Болзошгүй эрсдэл) санал солилцсон.

### **3.4. Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дэмжлэг**

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийн 6.4-д “Зөвлөлийн үйл ажиллагаанд УИХ-ын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс дэмжлэг үзүүлж, мэдээ, мэдээллээр хангаж ажиллана” гэж заасан байдаг. Үүний дагуу ТТБЗ нь УИХТГ-ын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс авсан зарим мэдээ, мэдээллийг дурдвал:

- Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд хийсэн дүн шинжилгээний талаарх товч танилцуулга;
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд хийсэн дүн шинжилгээний талаарх товч танилцуулга;
- Нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүн шинжилгээ хийсэн талаарх танилцуулга;
- Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга;
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны урьдчилсан гүйцэтгэлийн мэдээ;
- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2022 оны урьдчилсан гүйцэтгэл мэдээ;
- Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл, гол нэр төрлийн экспорт, импортын тоо хэмжээ, үнэ болон татварын орлого бүрдүүлэлтийн талаарх товч танилцуулга (2022 оны урьдчилсан гүйцэтгэл);
- Улсын Их Хурал, Засгийн газрын хурлаар хэлэлцэж буй зарим хууль тогтоомжийн төсөл;
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны 1-8 дугаар сарын гүйцэтгэл;
- Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, 1-7 дугаар сард олгосон санхүүжилт;
- Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл, гол нэр төрлийн экспорт, импортын тоо хэмжээ, үнэ болон татварын орлого бүрдүүлэлтийн талаарх товч танилцуулга (2023 оны 1-8 дугаар сарын гүйцэтгэл);
- Монгол Улсын макро эдийн засгийн 2023 оны 1 дүгээр улирал, хагас жилийн гүйцэтгэл;
- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналд хийсэн дүн шинжилгээ, дүгнэлт.

## **4. ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦСАН БАЙДАЛ**

Төсвийн бүрдлийг хангахад чиглэсэн эдийн засгийн бодлого явуулах, төсвийн сахилга батыг бэхжүүлэх, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн мөн чанарыг нийгэмд таниулах, энэ хүрээнд төсвийн алдагдлыг багасгаж, өр үүсэхээс сэргийлэх, хуримтлалыг төр, засгийн мэдэлд бус, хувь хүн, банкны хариуцлагад хуулиар албан журмаар шилжүүлж, урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэр бүрдүүлэх талаарх ТТБЗ-ийн санал, санаачилгыг нийт иргэдэд хүргэж, тэдний санал хүсэлт, дэмжлэг авах үүднээс дараах ярилцлага, мэдээллийг өгсөн.

- 2023.05.17-ны өдрийн Ийгл Телевизийн “Зочны цаг” нэвтрүүлгээр Төсвийн хүрээний мэдэгдэлд өгсөн зөвлөмжийн талаар ТТБЗ-ийн гишүүн Э.Бямбажавын ярилцлага;
- 2023.10.17-ны өдрийн Ийгл телевизийн тоон тойм нэвтрүүлгээр 2024 оны төсвийн төсөлд ТТБЗ-өөс өгсөн дүгнэлт, зөвлөмжийн талаар Л.Отгонтуяа гишүүний өгсөн ярилцлага;
- 2023.10.26-ны өдрийн Монгол Үндэсний телевизийн эдийн засгийн тойм нэвтрүүлгээр 2024 оны төсвийн төсөлд ТТБЗ-өөс өгсөн дүгнэлт, зөвлөмжийн талаар Д.Даваасамбуу даргын өгсөн ярилцлага.

## 5. ЗӨВЛӨЛИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зөвлөлийн хуралдаан: ТТБЗ цахим, танхимын хэлбэрээр 5 удаа хуралдсан. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн.

2023.01.16-ны өдрийн хуралдаанаар:

- Зөвлөлийн 2023 оны төлөвлөгөө боловсруулах тухай;
- Төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлэх хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн талаар;
- ТТБЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан;

2023.03.20-ны өдрийн хуралдаанаар:

- ТТБЗ-ийн 2022 оны тайланг батлах тухай;
- Төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн талаар ТТБЗ-өөс өгөх санал;
- ТТБЗ-ийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай;

2023.05.15-ны өдрийн хуралдаанаар:

- 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд өгөх зөвлөмж;
- Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд өгөх зөвлөмж;

2023.06.14-ны өдрийн хуралдаанаар:


- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх зөвлөмж;

2023.10.07-ны өдрийн хуралдаанаар:

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд өгөх зөвлөмж.

## ХАВСРАЛТУУД

### Хавсралт 1. ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын динамик (хувиар)



Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны төсвийн төслийн баримт бичиг

### Хавсралт 2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт

Хуулийн заалт/өөрчлөлт оруулсан огноо	2011-02-10	2011-11-23	2012-08-17	2015-01-20	2015-02-18	2015-04-09	2015-05-21	2015-11-10	2016-02-05	2016-09-09	2017-04-14	2017-04-14	2021-07-07
1. Хуулийн зорилт													
2. ТТБТХ тогтоомж (1)													
3. Хуулийн үйлчлэх хүрээ													
4. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт (3)													
5. Төсвийн удирдлагын зарчим													
6. Төсвийн тусгай шаардлага (ТТШ) (3)													
6 дугаар зүйлийн 6.1.4 дэх хэсэг: Засгийн газрын өр										60%			
7. Төсвийн тусгай шаардлага (ТТШ)-ыг баримтлах													
8. ТТШ-ын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх тохиолдол (1)													
9. Улсын Их Хурлын бүрэн эрх (1)													
10. Засгийн газрын бүрэн эрх (1)													
11. Сангийн яамны бүрэн эрх (1)													
12. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (1)													
13. Төсвийн тусгай шаардлагын хэрэгжилтэд хяналт тавих													
14. Төсвийн тусгай шаардлагын хэрэгжилтийг тайлагнах													
15. Төсвийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулахад үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах													
16. Төсвийн тогтворжуулалтын сан (3)													
17. Санхүүгийн хуримтлал, түүний хөрөнгө оруулалт (4)													
18. Хариуцагаа хүлээлгэх үндэслэл (1)													
19. Хуулийг дагаж мөрдөх журам (9)													
<b>Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал (2 хувь)</b>													
2015 он				5%						5%			
2016 он				4%					18.5%				
2017 он				3%					9.9%	10.4%	10.4%		
2018 он				2%					7.5%	9.5%	9.5%		
2019 он									5.5%	6.9%	6.9%		
2020 он									0%	5.1%	12.5%		
2021 он										3.6%	8.8%		
2022 он										2.8%	5.1%		
2023 он										2.0%	3.6%		
2024 он											2.8%		
2025 он											2.0%		
<b>Засгийн өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь (40%, 2016 оноос 60%)</b>													
2015 он				58.3%					58.3%				
2016 он				55%					88.0%				
2017 он				50%					85.0%				
2018 он				40%					80.0%				
2019 он									75.0%				
2020 он									70.0%				
2021 он									60.0%				70.0%
2022 он													70.0%
2023 он													65.0%
2024 он													60.0%
2025 он													

Тайлбар: Хуулийн заалтад орсон өөрчлөлтийг цэнхэр өнгөөр тэмдэглэв.

### **Хавсралт 3. Төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд өгсөн зөвлөмж**

2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ) танилцаад УИХ-ын 2017 оны 83 дугаар тогтоолоор баталсан зөвлөлийн дүрмийн 3.1.1 дэх заалтад тусгагдсан бүрэн эрхийн хүрээнд дор дурдсан дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

#### **ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ**

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үндсэн зорилт нь Монгол Улс байгалийн баялгаа эрчимтэй ашиглах явцдаа хуримтлал үүсгэх явдал юм. 2010 онд хууль батлагдсанаас хойш төрийн мэдэлд хүний хөгжил сан, тогтворжуулалтын сан, ирээдүй өв сан хэлбэрээр хуримтлал үүсгэх оролдлого хийж байна. Гэсэн хэдий ч тодорхой шалтгааны улмаас эдгээр санд хуримтлагдсан хөрөнгийг зарцуулах, төсвийн алдагдлыг нөхдөг, төсвийн орлого зарлагын бүрэлдэхүүн болгох эрх зүйн зохицуулалт хийлээ.

Энэхүү зохицуулалтыг хийхдээ төсвийг ашигтай байлгах, давагдашгүй хүчин зүйлийн улмаас төсвийн алдагдлыг ДНБ-ий хоёр хувиас хэтрүүлэхгүй байлгах, Засгийн газрын өрийг ДНБ-ий 40 хувиас хэтрүүлэхгүй байлгах төсвийн тусгай шаардлагуудыг хуулиар олон удаа өөрчилж, бодит хэрэг дээрээ суурь шаардлагуудыг хангаж чадсангүй. Үүний хамгийн тод илрэл бол улс, түүний дотор Засгийн газрын өрийн үлдэгдэл ДНБ-ий 60 гаруй хувийг даваад байна.

Үндсэн хуульд 2019 онд хийсэн нэмэлт, өөрчлөлтийн гол санаа бол баялгийн өгөөжийг одоо ба ирээдүй үеийнхэнд тэгш хувиарлах явдал билээ. Өөрөөр хэлбэл баялгийн өгөөжийг бүгдийг нь төсвөөр болон бусад санхүүгийн хэрэгслээр дамжуулан өнөө үеийнхэн хэрэглэх нь Үндсэн хууль зөрчсөн хэрэг болох юм.

Иймээс баялгаа эрчимтэй ашиглаж буй өнөө үед ирээдүй үеийнхэнд чиглэсэн хуримтлал бий болгох оновчтой арга замыг олж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн суурь зорилтыг хангах явдал бол хойшлуулшгүй зорилт болно. Ийм хуримтлалыг иргэдийн өндөр насны даатгалын (хувь хүмүүсийн төлдөг нийгмийн даатгал) шимтгэлийг иргэдийн мэдэлд үлдээх замаар бий болгох санал тавьж байна.

Ийм боломж нүүрс, зэснийн нөөцийг ашиглах болсон үед гарна. Энэ алтан боломжийг алдаж болохгүй. Иргэдэд тэдний төлдөг өндөр насны даатгалын шимтгэлийг үлдээснээр тэтгэврийн сан дампуурах эрсдэлээс хамгаалагдаж, иргэдийн даатгалын хамралт сайжирч, далд эдийн засаг арилгахад жинтэй хувь нэмэр болно. Мөн урт, дунд хугацааны томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх урт хугацааны эх үүсвэр бүрэлдэж, Монгол улс хуримтлалтай орон болж, иргэд ирээдүйдээ итгэлтэй урагшилна.

Өнөөгийн тэтгэврийг тодорхой хугацаанд хадгалж, яваандаа суурь тэтгэврийн хэсэг болгон хөгжүүлэх төсөөлөлтэй байна. Хадгаламжийн даатгалын үүсгэх тооцоо судалгаа, олон улсын туршлага, боловсруулж судалсан зүйл нэлээд байгаа ч цаашид нарийвчлан судлах, шийдэх асуудлууд олон бий, гол нь зарчмын том шийдвэрээ зоригтой хийхийг зөвлөж байна.

## 1. Нэгдсэн төсвийн орлого төлөвлөлттэй холбоотой санал:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хүрээнд дээр дурдсан сангууд (хүний хөгжил сан, тогтворжуулалтын сан, ирээдүй өв сан)-ыг төрийн мэдэлд байгуулаад үр дүнд хүрэхгүй байгаа учраас хуримтлалыг иргэдийн мэдэлд шилжүүлэх санал дэвшүүлж байна. Иргэдийн мэдэлд шилжүүлэх хэд хэдэн арга байж болно. Эдгээр аргуудаас дэлхийд шалгарсан арга нь хувь хүний өөрийн нэр дээрх өндөр насны тэтгэврийн даатгал юм. Иргэдийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг хувь хүний өөрийн нэр дээр иргэдийн сонгосон банканд хадгаламжийн данс үүсгэж 2024 оноос уул уурхайн орлогоос нөхөн төлөлт хийснээр дараах үр дүнд хүрнэ гэж үзэж байна. Үүнд:
  - Үндэсний статистикийн хороо 2021 онд 2,360.7 тэрбум төгрөгийн тэтгэврийн даатгалын сангийн орлого төвлөрүүлснийг мэдээлсэн байна (Хавсралт 1-т үзүүлэв). Иймд 2024 оноос хувь хүний төлсөн (ажил олгогчийн бус) тэтгэврийн даатгалын шимтгэл буюу 2,360.7 тэрбум төгрөгийн тал болох 1,180.3 тэрбум төгрөгийг уул уурхайн салбараас улсын төсөвт төвлөрч байгаа орлогоос иргэдийн ирээдүйн хөгжилд тэтгэврийн даатгалын сангаар дамжуулан зориулах шаардлагатай. Үүнийг хэрэгжүүлснээр иргэд тэтгэвэртээ гарах үедээ хуримтлалтай болж ирээдүйдээ итгэх итгэл нь сайжирна. (Иймд хэрэв шаардлагатай бол энэ хуримтлал үүсэж байгаа дүнгээс илүүгүйгээр төсвийг алдагдалтай батлахыг зөвшөөрөх).
  - Банкин дахь иргэдийн хадгаламж өссөнөөр Монгол Улс асар их хуримтлалтай болно. Хорь, гучин жилийн дараа Оюутолгой, Тавантолгойн нөөц дуусах үед ийм хэмжээний хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй болж эдийн засгийн хөгжлийг хөтлөх гол хэрэгсэл болно.
  - Хөрөнгө оруулалтын сангуудын менежмент сайжирч, үйл ажиллагаа жигдэрч, иргэдийн мэдлэг нэмэгдэх үед буюу 5 жилийн дараагаас иргэдэд хадгаламжаар нь байлгах, эсвэл хөрөнгийн зах зээлд оролцох, хувьцаа авах эсвэл хөрөнгө оруулалтын санд хадгаламжид байгаа хуримтлалаа хийхээ сонгох эрхийг нээе. Энэ нь хөрөнгийн зах зээлийг дэмжих санхүүгийн эх үүсвэр болох юм.
  - Тэтгэврийн даатгалын сангийн тодорхой хэсгийг цаашдаа иргэд 40-н нас хүрсний дараа орон сууц худалдан авах, эмчилгээний зардалд зарцуулах эрх олгох. Энэ нь иргэдийн амьдралын баталгааг бий болгохоос гадна энэ сангийн хөрөнгийг өсгөх нэг хөшүүрэг болох юм.
  - Иргэд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансандаа хуримтлалтай болсноор зарим хувийн секторт хэрэгжиж буй тус төрлийн даатгалын шимтгэлийг багаар тохиролцож төлдөг далд эдийн засаг багасаж Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт 2-оос 3 дахин нэмэгдэх боломжтой юм.
- 2020 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн Татварын багц хуулийн шинэчлэл, ковидын үеийн татварын бодлого, 2021 оноос шинээр хэрэгжсэн “Малын тоо толгойн албан татвар” зэрэг татварын бодлогын хэрэгжилтийн нөлөө, бодит байдал 2024 оны төсвийн орлого бүрдэлтэд хэрхэн нөлөөлөх талаар дүн шинжилгээ хийж, нарийвчлан тусгах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, татварын орлогын төсөөлөл хийх арга зүй, тооцооллын үндэслэлийг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.
- Татварын орлого төвлөрүүлэхэд учирч болох эрсдэлийн тооцооллыг бодит секторын үйлдвэрлэл, хөгжил, орлого, үр дүнтэй уялдуулан хийх шаардлагатай. Учир нь татварын байгууллага эрсдэлд суурилсан татварын хяналт, удирдлагын тогтолцоог хараахан бүрдүүлж чадаагүй байгаа тул татвар төлөгчид, бизнес эрхлэгчдийн бодит орлого, түүнээс төсөвт төвлөрүүлэх татварын орлогын таамаглал бодитой, бүрэн

үндэслэлтэй гэж үзэх нь эргэлзээтэй (2024 оны ТХМ боловсруулахад ашигласан тоон өгөгдөл, тооцоолол тодорхойгүй байна).

- Төрийн хэмнэлтийн хууль болон бусад бодлогын үр дүнд татварын бус орлогыг нэмэгдүүлэх ямар нөөц боломж байгаад дүн шинжилгээ хийж, татварын бус орлогыг бодитой төлөвлөх. Тухайлбал, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн сахилга бат, ашигт ажиллагааг нэмэгдүүлснээр ногдол ашиг болон татварын бус бусад орлогын эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.
- Ирээдүйн өв сангийн хуулийг өөрчлөн, хараат бус Баялгийн сан байгуулж зөвхөн хөрөнгө хадгалах бус, сангаа арвижуулах, гадаадын хөрөнгө оруулалт татах гол үүрэгтэйгээр болгож уг сангийн тодорхой хэсгийг албан журмын үндсэн дээр хуулиар хүүхдийн болон өндөр насны хадгаламж хэлбэрээр банкинд хуримтлуулах нь нийт эдийн засгийг урт, дунд хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй болгохын зэрэгцээ хүн амын хадгаламжгүй, өнөө маргаашаа аргацааж буй хэсгийн ирээдүйн амьдралын баталгааг бий болгож, аз жаргалтай, эрүүл амьдралыг бодит утгаар нь хэрэгжүүлэх боломж байгааг сайтар судалж шийдэх нь зүйтэй байна.

## **2. Нэгдсэн төсвийн зарлагатай холбоотой санал:**

- Хуулийн нийцэл, мөрдөлтийн асуудлыг хөндөн тавих шаардлага үүсэж байна. УИХ-аас хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах Үндсэн хуулиар олгогдсон онцгой эрхийн хүрээнд Төсвийн тогтвортой байдлын тухай 2010 оны хуульд 13 удаа өөрчлөлт оруулсан. Мөн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг жил бүрийн 5 дугаар сард хуульчлан тогтоогоод дараа жилийн төсөв батлах үедээ өөрчилдөг явдал үргэлжилсээр байна. Монгол Улс 2012-2022 оны хооронд 10 удаа батлах ёстой дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг нийт 30 удаа Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан. Иймд төсвийн тогтвортой байдлын тухай 2010 оны хуульд заасан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, төсвийн тоо, баримтуудыг ангилж, заавал мөрдөх, эсвэл зорилт үүрэг болгох, эсвэл баримжаа үзүүлэлт хэлбэрээр ялгаж, олон улсын чиг хандлагын дагуу төсвийн хүрээний мэдэгдлээс илүүтэй дунд хугацааны зарлагын хүрээ, хязгаар болгон шинэчилж, төсөв захирагчдын үүрэг хариуцлага, эрхийг нэмэгдүүлэх асуудлыг судлах хэрэгтэй байна.
- Монгол Улсын нэгдсэн төсөв 2018 оныг эс тооцвол 2011 хойш тогтмол алдагдалтай явж ирсэн бөгөөд алдагдлыг дотоод, гадаадын зээлээр санхүүжүүлж ирсэн. Төсвийг алдагдалтай батлахад халамж, хөрөнгө оруулалтын зардлын өсөлт ихээхэн нөлөөлж байгаа бөгөөд энэ нь импортыг дэмжиж, валютын ханшийг унагаж, инфляцыг өсгөхөд ихээхэн нөлөөлж байна. Иймд Оюу толгойн далд уурхай ашиглалтад орж төсвийн орлого нэмэгдэх энэхүү алтан боломжийг ашиглан төсвөө алдагдалгүй баталж гадаад зээл, хүүний дарамтаас салах зайлшгүй шаардлагатай байна. Төсвийн алдагдлыг 2024 оноос биш ч гэсэн үе шаттайгаар бууруулах зарчмаар төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг баталдаг болох шаардлагатай байна.
- 2022 оны туршид ам.доллартой харьцах төгрөгийн ханш 20.8 (2,849.3-3,444.6) хувиар унасан. Үүнээс шалтгаалан төгрөгийн хадгаламж буурч байна. Гадаад валютын харилцах дансны үлдэгдэл оны эцэст 4,946.8 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оноос 2.1 дахин нэмэгдэж, гадаад валютын хадгаламж 773.1 тэрбум төгрөг буюу 19.7 хувиар тус тус өссөн байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улс валютын ханшаа зохистойгоор зохицуулж чадахгүй, валютын бирж ажиллуулахгүй байгаагаас ханшийн огцом өөрчлөлт гарсаар байна. Төгрөгийн ханшийн уналт, инфляцын өсөлтөөс шалтгаалан иргэдийн цалин хүрэлцэхээ больж банкин дахь харилцах, хадгаламжаа татаж байна. 2021 онд ДНБ-д эзлэх мөнгөний нийлүүлэлт 64 хувь байсан бол 2022 онд 56.1 хувь болж буураад байна. Үнийн өсөлтийн талаарх



судалгаа ч УИХ төсвийг олон жил алдагдалтай баталж ирсний нэг үр дүн гэж харж болохоор байна. Иймд төсвийг алдагдалгүй баталж, эдийн засгийн суурь үзүүлэлтүүд болох инфляц, валютын ханш, иргэдийн хуримтлал зэрэг макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг төсвийн бодлогоор дэмжих, шаардлагатай арга хэмжээг авах ёстой.

- ТХМ-ийн төсөлд тусгагдсан 2024 оны дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 32.3 хувь, нийт зарлага 35.1 хувь байгаа нь өндөр хэвээр байна. Мөн 2025-2026 онуудад бага зэрэг бууруулахаар төсөөлсөн хэдий ч энэ нь олон улсын жишгээс өндөр хэвээр байна. Иймд дунд хугацааны төсвийн төсөөлөлдөө дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлагын хувийг буулгаж 28-30 хувьд хүргэж, хувийн хэвшлийн байгууллагуудад бизнес хийх орон зайг үлдээх нь төсвийг үр ашигтай зарцуулах, алдагдалгүй батлах, эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг төсвийн бодлогоороо дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.
- Төсвийн орлого нь уул, уурхайн бүтээгдэхүүний орлого, валютын ханшийн өсөлтөөс шалтгаалан нэмэгдэж байгаа ч эдгээрийн үнэ буурсан үед орлого дагаж өссөн зардлыг бууруулахад хүндрэл үүсэх эрсдэл нэмэгдсээр байна. Үүнээс сэргийлэхийн тулд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зардлын хязгаарыг тогтоосон шалгуур үзүүлэлт нэмэлтээр оруулах нь зүйтэй. ТТБЗ-өөс төсвийн нийт зарлагыг дотоодын нийт бүтээгдэхүүний 28-30 хувиас ихгүй байхаар төсвийн төслийг боловсруулах нь зохимжтой гэсэн саналтай байна. Дээр бичсэнээр үе шаттайгаар төсвийн алдагдлаа бууруулах нь чухал зорилт юм.
- Төсвийн санхүүжилтийн дарамтыг бууруулах шаардлагатай. Цар тахлын хүндрэлийн үе дууссан тул төсвийн зардлаа тогтворжуулахад чиглэсэн тохируулгаа нэн яаралтай эхлүүлэх шаардлагатай. Олон улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл хатуурсан, хүү өссөн, бусад улс орнуудын өрийн хүндрэлтэй нүүр тулж байгаа тул Монгол Улс урьдчилж зардлаа бууруулах хэрэгтэй. Төсвийн орлогын төсөөлөл нь 45-50 сая тонн нүүрс экспортлох төлөвлөгөөнд найдаж зардлаа нэмэх нь гадаад валютын нөөцийг шавхах, өрийн тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй. Төсвийн зарлагыг бууруулах нэг гол арга хэмжээ бол бүтцийн өөрчлөлт хийх, хэт олон яам, агентлагуудыг цөөрүүлэх ажлыг 2024-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөмөөр байна.
- Нийгмийн халамжийн бодлогыг зорилтот бүлэгт чиглүүлэх шаардлагатай. Энэ нь Засгийн газрын өр, инфляц, валютын ханшийн сөрөг нөлөөллийг бууруулахын зэрэгцээ мал аж ахуйн салбарын эдийн засгийн эргэлтийг сайжруулахад ч эерэг нөлөө үзүүлнэ. Нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж зэрэг нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой нийт зардлын нарийвчилсан тооцоолол, тухайлбал, хүүхдийн мөнгийг ямар бүлэгт, ямар хэмжээгээр олгохоор төлөвлөсөн, тэтгэврийн шинэчлэлтэй холбоотойгоор төсвийн ачаалал цаашид хэр нэмэгдэх гэх мэт нь тодорхойгүй байна.
- Урсгал зардлын тооцоолол, үндэслэлийг тодорхой гаргах шаардлагатай. Боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээний салбаруудад хэрэгжүүлж буй төсвийн шинэчлэлийн үр дүнд төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр өгөөж нэмэгдэх эсэх талаарх тооцоолол, харьцуулсан судалгаа хангалтгүй байна.
- Сонгуулийн болон өмнөх жилд төсвийн зарлага сүүлийн 20 жилд дунджаар 2 жил дараалан 26-27 хувиар, зарим жилүүдэд 40 гаруй хувиар өсдөг хандлагыг давтахгүй байх нь зүйтэй.

### 3. Төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой санал:

- Улсын төсвөөр 2023 онд хийгдэх хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд өмнөх жилүүдэд эхлүүлсэн төслүүдээ дуусгах, шинэ төсөл эхлүүлэхгүй байх, барилгын материалын үнийн өсөлтийн санхүүжилтийг бүрэн олгох болон гадаадын зээл тусламжийн төслүүдийн Монголын талын хариуцах хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зарчим баримталж, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байгаа бөгөөд ирэх жилээс эхлэн төсвийн хөрөнгө оруулалтаар олон төслүүдийг нэгэн зэрэг эхлүүлж, жил дамнан бүтээн байгуулах бус, цөөн тооны ач холбогдол өндөртэй төслүүдэд илүү ач холбогдол өгч богино хугацаанд эдийн засгийн эргэлтэд оруулахад анхаарах нь тухайн төслийн өртөг жил бүр өсөх, үйлдвэрлэлийн явц удааширч алдагдсан боломжийн өртөг нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөг бууруулах боломжтой юм.
- Хөрөнгийн зардал 2024 оны сонгуультай холбоотойгоор төсөвт нэмэлт ачаалал үүсгэх эсэх, шууд болон дам хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг тооцож, ялангуяа барилга байгууламжид оруулах хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлэхгүй байхад анхаарах шаардлагатай.
- Төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг шийдвэрлэхдээ жижиг сум, суурины барилга барих, зам хашлага солих гэх мэтээс илүүтэйгээр Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд эдийн засгийн тэлэлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг шийдвэрлэхэд тэргүүн зэргийн ач холбогдол өгөх нь зүйтэй. Тухайлбал,
  - Автозамын төслүүдийг эдийн засгийн өгөөж, бүс нутгийн онцлогт тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тээвэр, ачаа эргэлт, үйлдвэрлэлийн бүсийн гол замуудыг тэргүүн зорилт болгож онцлогт нь тохирсон чанартай зам барих нь урт хугацаандаа тээврийн зардлыг бууруулах, замын арчилгааны зардлыг багасгах, цаашлаад олон улсын транзит тээврийг хөгжүүлэх зэргээр урт, дунд хугацааны Монгол Улсын хөгжлийн бодлоготой уялдуулах боломжтой.
  - Монгол Улс цахилгаан эрчим хүчний хэрэглээнийхээ 20 орчим хувийг импортоор авч, жилдээ 180 сая гаруй ам.долларыг импортын эрчим хүчний төлбөрт төлж байна. Энэхүү асуудал нь олон жил үргэлжилж, ялангуяа говийн үйлдвэрийн бүсүүдэд эрчим хүчний эх үүсвэр нэн шаардлагатай байгаа ч удааширсан хэвээр байна. Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд хэд хэдэн эрчим хүчний төслүүд, өргөтгөлийн ажлуудыг тусгасан байгаа хэдий ч ойрын хугацаанд ашиглалтад орох томоохон хүчин чадал бүхий эрчим хүчний үйлдвэрүүд байхгүй байна. Энэ салбарын хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхдээ олон улсад сүүлийн жилүүдэд баримталж буй нүүрсний дулаан, цахилгааны станцуудаас татгалзах, үүний оронд цэвэр, сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэхэд төрөл бүрийн бодлогын арга хэмжээ, санаачилгуудыг харгалзан үзэх нь зүйтэй. Иймд, дэлхий нийтээр хүлэмжийн хийг бууруулах зорилтыг хангах хүрээнд нүүрстөрөгчийн үнийн (carbon pricing) тооцоог хийж, урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, жил бүрийн хөгжлийн төлөвлөгөөнд үе шаттайгаар тусгаж хэрэгжүүлэх нь чухал.
- Дэд бүтцийн том төслүүд хэрэгжиж байгаа үед төсвийн бусад үр ашиг муутай, хэрэглээ, урсгал зардлыг нэмэгдүүлсэн хөрөнгө оруулалтыг танах шаардлагатай.
- Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашигт үндэслэн эрэмбэ дарааллыг зөв тодорхойлох шаардлагатай. Ингэснээр эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх суурь нөхцөл болохын зэрэгцээ дотоод эдийн засагт, хувийн секторт, өрхийн амьжиргаанд дарамт учруулахгүй. Тухайлбал, Таван толгойн нүүрсний ордоос Ханги, Гашуун-Сухайтын

чиглэлд 2 төмөр зам барьж хилийн бүсэд хүргээд байгаа хэдий ч аль нь ч БНХАУ-ын талын төмөр замтай холбогдоогүй байна. Иймээс өндөр өртөг бүхий ижил төстэй төслүүдийг нэг дор эхлүүлэх бус ач холбогдлоор эрэмбэлэн бүтээн байгуулалтын ажлыг бүрэн гүйцэтгэж, үйл ажиллагаа нь жигдэрсний дараа шат дараатай хүчин чадлыг нэмэгдүүлж, төрөлжүүлэх нь төсөв болон валютын нөөцөд ирэх ачааллыг бууруулах, дотоодын нөөцийн хүчин чадлыг зохистой ашиглах зэрэг эерэг үр дагавартай.

- Урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг шийдэхдээ өмнө нь хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнд үндэслэдэг байх хэрэгтэй. Мах, гурил зэрэг бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах чиглэлээр хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн боловч үнийн өсөлт үргэлжилсээр байна. Тухайлбал, махны нөөц бүрдүүлэх, зарим нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор жил бүр хөнгөлөлттэй зээл олгож байгаа хэдий ч үр дүн муутай, улирлын шинж чанартай нийлүүлэлт доголдож, үнэ хэлбэлздэг хэвээр байна.
- Төсвийн зардлын үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд хөнгөлөлттэй зээлээр түр зуур аргацаасан арга хэмжээ авахаас илүүтэйгээр зах зээлийн зарчимд суурилсан тогтвортой нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход анхаарах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, олон улсын сайн жишигт нийцсэн нийлүүлэлтийн гинжин сүлжээ, кластер тогтолцоо, түүнд шаардлагатай дэд бүтэц, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд илүүтэй анхаарах нь хөгжлийн бодлогын чухал хэсэг юм.

#### 4. Засгийн газрын өртэй холбоотой санал:

- Засгийн газрын өр, өрийн дарамтыг бууруулах чиглэлээр баримтлах бодлогод зарчмын өөрчлөлт, шинэчлэл хийх шаардлагатай байна. Өрийг өрөөр санхүүжүүлдэг тогтолцоог халах шаардлага, эрсдэл бодитойгоор үүссэн гэж үзэж байна.
- Засгийн газрын өрийн үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 31,964.3 тэрбум төгрөг буюу нэрлэсэн ДНБ-ий 60.3 хувьтай тэнцэж байна. Гэвч Засгийн газрын өнөөгийн үнэ цэнээр тооцсон өрийн хэмжээ 27,726.6 тэрбум төгрөг болсон бөгөөд ДНБ-ий 52.4 хувийг эзэлж байгаа талаар ТХМ-ийн танилцуулгад дурджээ. Олон улсад их хэрэглэгддэггүй аргаар (өнөөгийн үнэ цэнээр тооцох) зээлийн хэмжээг бууруулан тооцож, мэдээллийн зөрүүтэй байдал бий болгохыг эцэслэх нь зүйтэй. Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2015 онд оруулсан нэмэлт 6.2 дахь хэсгийн дагуу (*Засгийн газрын өрийн хязгаар нь эрчим хүч, төмөр зам, уул уурхайн салбарын хуулийн этгээдэд Засгийн газар хувь нийлүүлсэн хөрөнгө оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ашигаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгаанд хамаарахгүй*) өрийг хасаж тооцон бодит өрийн хэмжээнд зөрүүтэй мэдээлэл бий болгож байгааг эцэслэх шаардлагатай байна.
- Төсвийн алдагдал, эсвэл алдагдалтай ч төсвийн зардлыг нэмэгдүүлэх, зарим салбарын өрийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулан тооцохгүй байгаа нь эцсийн дүндээ өр зээл өсөх шалтгаан болсон. Монгол Улсын хувьд Улсын төсвийн алдагдлыг дотоод, гадаадын өр болон тусламжаар санхүүжүүлсээр ирсэн бөгөөд Төсвийн тогтвортой байдлыг хангах үүднээс өр болон ДНБ-ий харьцааны дээд хязгаарыг энэ хуулиар баталж, урт хугацаанд өрийг бууруулах стратеги баримталж байгаа боловч хуульд тусгагдсан энэхүү өрийн дээд хязгаарыг төсөв хэлэлцэх үеэр удаа дараа өөрчилж, хуульд заасан хэрэгжих хугацааг нь хойшлуулсан өөрчлөлт оруулсаар байна. Монгол Улсын Засгийн газар, Монголбанк тулгамдсан өр зээлийг хойшлуулсан, бага хүүтэй бонд, зээлийн хэрэгслээр дахин санхүүжилт

хийж богино хугацаандаа хүндрэлийг зөөлрүүлсэн сайн талтай ч хойшилсон өр, нэмэгдсэн зээлийн үйлчилгээний төлбөр дарамт болж үлдсээр байгааг хязгаарлах шаардлага өссөөр байна.

- Өр нэмэгдэж буй гол шалтгаан бол төсвийн алдагдлаас гадна Монгол Улсын төлбөрийн урсгал тэнцэл олон жил алдагдалтай гарч, улмаар төсөвт ихээхэн ачаалал нэмэх хандлагатай болсонтой холбоотой. Урсгал данс ийнхүү алдагдалтай байгаа нь гадаадаас авах санхүүжилтийн хэрэгцээг үүсгэж байна. Иймд экспортлогчдыг төрөөс тусгайлан дэмжих хэрэгтэй гэдэгт бүгд санал нэгдэж, экспортыг дэмжих олон улсын сайн жишиг болсон механизм, арга хэрэгслийг нарийвчлан судалж, хэрэгжүүлэх нь чухал. Экспортод чиглэсэн үйлдвэрлэгчдийг тэргүүн байранд тавьж, бүх талын туслалцаа үзүүлэх, экспортыг хааж боогдуулдаг аливаа шийдвэр нь үндэсний эрх ашигт үл нийцэх бөгөөд ийм үйлдэл гаргахааргүй зарчим, журам тогтоох хэрэгтэй. Зах зээл судлал, үнэ, тарифын орчин, реклам сурталчилгааг эрс сайжруулж, төрийн дэмжлэг үзүүлж, эрсдэлийг бууруулахад чиглэсэн батлан даалт, экспортын санхүүжилтийн болон даатгалын сан, холбогдох арга хэрэгслийг бий болгох хэрэгцээ үүсээд байна.
- Засгийн газрын өрийг бууруулахад сөрөг нөлөөлж буй Өрийн удирдлагын тухай хуулийн олон заалт байгааг 2023 онд засаж өөрчлөх шаардлагатай байна. Энэ талаар ТТБЗ саналаа Төсвийн байнгын хорооны даргад хүргүүлсэн. Энэ хуульд зохих өөрчлөлт оруулж мөрдвөл 2024-2025 онуудад Засгийн газрын өрийг бууруулахад чухал нөлөө үзүүлэх болно.
- Үндэсний хуримтлал болон дотоодын үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлэх шаардлагатай. Үндэсний хуримтлал, ажиллах хүчний оролцооны түвшин бусад орнуудтай харьцуулахад нэн доогуур байгаа нь суурь асуудал бөгөөд өр үүсэх үндсэн шалтгаан мөн. Төсөв, мөнгө болон эдийн засгийн бодлого хэрэгслийг юуны түрүүнд дотоод хуримтлал бий болгох, цаашлаад хөрөнгө оруулалтын урт хугацаатай эх үүсвэрийг бүрдүүлэх, улмаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд чиглүүлэх замаар гадаад зээлийн хэрэгцээг багасгаж, Монгол Улсын түүхий эд, хүний нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, үүний дотор ажиллах хүчний чадавхыг дээшлүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна.

## УЛС ОРНЫ ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 1. Эдийн засгийн өсөлт

Олон улсын валютын сангийн төсөөллөөс үзэхэд 2024 онд дэлхийн эдийн засаг 3 хувиар өсөх бол хөгжиж буй орнуудаас БНХАУ-ын эдийн засаг 4.5 хувь, ОХУ-ын эдийн засаг 1.3 хувийн өсөлттэй байхаар таамагласан байна.

*Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтийн таамаглал*

	2022 он	2023 он	2024 он
<b>ДЭЛХИЙ</b>	<b>3.4</b>	<b>2.8</b>	<b>3.0</b>
<b>Хөгжингүй орнууд</b>	<b>2.7</b>	<b>1.3</b>	<b>1.4</b>
АНУ	2.1	1.6	1.1
Евро бүс	3.5	0.8	1.4
Япон	1.1	1.3	1.0
<b>Хөгжиж буй орнууд</b>	<b>4.0</b>	<b>3.9</b>	<b>4.2</b>
БНХАУ	3.0	5.2	4.5
ОХУ	-2.1	0.7	1.3
Монгол Улс	4.8	4.5	5.5

*Эх сурвалж: ОУВС (2023.04)*


Монгол Улсын нэрлэсэн ДНБ 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 52.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 21.4 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 28.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 4.8 хувиар өсжээ. Эдийн засгийн 2022 оны бодит өсөлтийг салбараар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 12.0 хувиар, худалдааны салбар 8.0 хувиар, барилгын салбар 7.9 хувиар, үйлчилгээний салбар 4.9 хувиар, тээврийн салбар 3.0 хувиар тэлсэн нь нийт өсөлтийг дэмжсэн бол уул уурхайн салбар 11.9 хувиар агшсан нь нийт өсөлтийг хязгаарласан байна. 2023 онд эдийн засгийн өсөлтийг 5 хувь байхаар төлөвлөсөн бол хүлээгдэж буй гүйцэтгэлээр жилийн эцэст 6.0 хувьд хүргэхээр Засгийн газар төсөөлжээ.

2024 оны төсвийн хүрээний мэдэгдлээс үзэхэд энэхүү өсөлт хадгалагдаж 6.5 хувь байхаар тооцоолсон нь ОУВС-ийн тооцоноос 1 нэгж хувиар илүү үзүүлэлт юм.

## 2. Инфляц


Инфляцын түвшин 2022 оны жилийн эцсийн байдлаар 13.2 хувь байсан нь өмнөх оноос 0.2 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Нөгөө талд банкнуудын 2022 оны 12 дугаар сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 10.9 хувь байсан нь инфляцын түвшин болон Монголбанкны бодлогын хүүнээс бага бөгөөд энэ нь иргэд, ААН-үүд арилжааны банкин дахь төгрөгийн хадгаламжаа нэмэгдүүлэхийг дэмжих үзүүлэлт болж чадахааргүй байна.

Зураг 1. Инфляцын түвшин



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2. Шинээр татсан төгрөг, валютын хадгаламжийн ЖДХ



Эх сурвалж: Монголбанк

Харин инфляц 2023 оны эхний улирлын байдлаар 12 орчим хувьтай байгааг оны эцэст нэг оронтой тоонд хүргэхээр зорьж байгаа ч дэлхий дахины тодорхойгүй нөхцөл сөрөг нөлөө үзүүлэх талтай. Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр зээлийн хүү өсөж, зээлийн өсөлт саарч эхэлсэн, мөн өмнөх оны суурь үнэ өндөр байсан зэргээс шалтгаалан инфляц буурах хүлээлттэй байгаа хэдий ч худалдааны түнш орнуудын өндөр инфляц, геополитикийн нөхцөл байдал, эрчим хүчний үнийн өсөлт, төгрөгийн ханшийн сулрал зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан инфляц өсөх магадлал өндөр, зорилтот түвшинд хүргэх боломж бага, эрсдэлтэй хэвээр байна.


## 3. Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт 2022 оны эцэст 29,664.8 тэрбум төгрөг болж 2021 оноос 1,801.3 тэрбум төгрөг буюу 6.5 хувиар өссөн байна. Харин төгрөгийн хадгаламж 16.1 хувь буюу 2,416.4 тэрбум төгрөгөөр буурчээ. 2022 оны жилийн эцсийн байдлаар гадаад валютын

харилцах 4,946.8 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оноос 2.1 дахин нэмэгдэж, гадаад валютын хадгаламж 773.1 тэрбум төгрөг буюу 19.7 хувиар өссөн байна.

Сүүлийн үед төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой байна. Түүнийг дагаад төгрөгийн хадгаламж өснө гэсэн найдлага байна. Энэхүү нааштай үр дүн нь цаашдаа төсөв, төлбөрийн тэнцлийг сайжруулах боловч төр засгийн бодлого, олон улсын зах зээлийн байдлаас ихээхэн хамаарах болно.

Зураг 3. Мөнгөний нийлүүлэлт, 2019-2022 оноор



Эх сурвалж: Монголбанк

ДНБ-д харьцуулсан мөнгөний нийлүүлэлт 2021 онд 64.0 хувь байсан бол 2022 онд 56.1 хувь болж буугаад байна. Энэ нь эцсийн дүндээ хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх эх үүсвэр хомс болж байгааг харуулж байна.

#### 4. Төлбөрийн тэнцэл

2022 оны байдлаар урсгал тэнцлийн алдагдал 2,303.5 сая ам.доллар байна. Хэдийгээр бараа бүтээгдэхүүний худалдаа 1,232.5 сая ам.доллар, хоёрдогч орлого 434.1 сая ам.долларын ашигтай гарсан ч үйлчилгээний тэнцэл 2,355.0 сая ам.доллар, мөн анхдагч орлого 1,615.1 сая ам.долларын алдагдалтай байгаа нь нийт урсгал тэнцэл алдагдалтай гарахад нөлөөлсөн байна. Энэ нь Монгол Улсын гадаад өр их, үүнээс улбаалсан зээлийн үйлчилгээний төлбөр өндөр, гадаад дотоодын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, үйлчилгээнд Монголын талын оролцоо бага болохыг харуулж байна.

Хүснэгт 2. Төлбөрийн тэнцэл, 2019-2022 оны байдлаар /сая ам.доллаароор/

Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2022 он	Зөрүү
<b>I. УРСГАЛ ДАНС</b>	<b>-2,161.7</b>	<b>-674.6</b>	<b>-2,108.4</b>	<b>-2,303.5</b>	<b>-195.1</b>
1. Бараа	1,158.1	1,755.6	1,369.6	1,232.5	-137.1
2. Үйлчилгээ	-1,991.7	-1,450.2	-1,675.4	-2,355.0	-679.7
3. Анхдагч орлого	-1,568.8	-1,253.3	-2,231.8	-1,615.1	616.7
4. Хоёрдогч орлого	240.7	273.3	429.1	434.1	5.0
<b>II. ХӨРӨНГИЙН ДАНС</b>	<b>160.8</b>	<b>102.8</b>	<b>114.0</b>	<b>154.3</b>	<b>40.3</b>
III. САНХҮҮГИЙН ДАНС	-2,677.7	-1,504.2	-1,982.2	-1,644.1	338.1
IV. Алдаа болон орхигдуулга	-223.9	-145.6	-209.4	-222.1	-12.7
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	452.9	786.9	-221.6	-727.3	-505.6

Эх сурвалж: Монголбанк

Энэхүү урсгал тэнцлийн алдагдлыг гадаад шууд хөрөнгө оруулалт, зээл тусламж зэрэг 1,644.1 сая ам.доллараар нөхөж, үлдэгдэл 727.3 сая ам.долларыг валютын нөөцөөр санхүүжүүлсэн байна.

## 5. Засгийн газрын гадаад бонд, зээлийн өр

Монгол Улсын Засгийн газар 2022 оны 12 дугаар сард “Чингис” бондын үлдэгдэл болох 136.8 сая ам.долларын өрийг Улсын төсвийн мөнгөн хөрөнгөөс төлж оны эцэст 8,009.4 сая ам.долларын өртэй гарсан байна. Үүнээс гадаад бондын өр үлдэгдэл 2,717.3 сая ам.доллар байна.

*Хүснэгт 3. 2022 оны эцсээрх гадаад бондын үлдэгдэл /сая ам.доллараар/*

№	Гадаад үнэт цаас	Хүү	Хугацаа	Үлдэгдэл
1	Хуралдай	8.75	7 жил	600.0
2	Гэрэгэ	5.625	5.5 жил	517.3
3	Номад	5.125	5.5 жил	600.0
4	Сенчири-2027	3.5	6 жил	500.0
5	Сенчири-2031	4.45	10 жил	500.0
<b>НИЙТ</b>				<b>2,717.3</b>

*Эх сурвалж: Сангийн яам*

2023 оны 1 дүгээр сард 650 сая ам.долларын “Сенчири-2” бондын гаргаж “Хуралдай” бондын 209.3 сая ам.доллар, “Гэрэгэ” бондын 435.3 сая ам.долларын өрийг дахин санхүүжүүлсэн бол 2023 оны 5 дугаар сард Улсын төсвийн хөрөнгөөс “Гэрэгэ” бондын үлдэгдэл 82 сая ам.долларыг төлж барагдуулсан байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс тухайн жилд төлөгдөх нийт өрийн 20-30 хувийг улсын төсвийн хөрөнгөөр төлж, үлдэгдэл төлбөрийг дахин санхүүжүүлэх зөвлөмжийг өгч байсан. Гадаад өрийн болон хүүний дарамтыг шат дараатайгаар бууруулах нь төлбөрийн тэнцэл, валютын ханш, инфляц зэрэг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд сайжрахад чухал нөлөө үзүүлэх тул төсвийг алдагдалтай төсөвлөж өр нэмэхгүй байхад анхаарах шаардлагатай байна.

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 31,964.3 тэрбум төгрөг буюу нэрлэсэн ДНБ-ий 60.3 хувьтай тэнцэж байна. Засгийн газрын нийт өрийн 3.2 хувийг Засгийн газрын дотоод үнэт цаасны өр, 92.7 хувийг Засгийн газрын гадаад өр, түүний дотор гадаад зээлийн өр 63.5 хувийг нь эзэлж байгаа юм. Түүнчлэн Засгийн газрын өнөөгийн үнэ цэнээр тооцсон өрийн хэмжээ 27,726.6 тэрбум төгрөг болсон бөгөөд ДНБ-ий 52.4 хувийг эзэлж байна. Төсвийн тогтвортой байдлын хуульд 2021 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр ДНБ-д эзлэх Засгийн газрын өнөөгийн үнэ цэнээр тооцсон өрийн хязгаарыг анх батлагдсан (40%)-аас 75 хувиар нэмэгдүүлж 70 хувь болгон өсгөсөнтэй харьцуулахад хуулиар тогтоосон өрийн хязгаарт багтаж байгаа мэт боловч 2010 онд батлагдсан хуулийн тусгай шаардлагын хэмжээнээс энэ үзүүлэлт урьдчилсан гүйцэтгэлээр даруй 12.4 нэгж хувиар давж байгаа юм.

## 6. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2024 онд 21,163.2 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 11.1 хувиар өсөх төслийг өргөн мэдүүлсэн байна. Хэрэв 2024 онд инфляцыг нэг оронтой тоод барьж, валютын ханш тогтвортой байна гэсэн төсөөллийн дагуу тооцвол төсвийн орлого биелнэ гэж таамаглаж байна. Төсвийн нийт зарлага 2024 онд 22,996.1 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 12.3 хувиар нэмэгджээ.

**Хүснэгт 4. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн харьцуулалт**

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2023 оны	2024 оны	Зөрүү	Төсвийн төсөөлөл	
		Бат.ТХМ	ТХМ		2025 он	2026 он
		/2022.11.11/	төсөл		4	5
		1	2	3=2-1		
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.0	6.5	1.5	6.5	5.4
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	8.0	0.0	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	19,049.6	21,163.2	2,113.6	22,472.0	24,089.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	34.9	32.3	-2.6	30.9	30.4
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	20,475.3	22,996.1	2,520.8	23,928.8	25,676.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	37.6	35.1	-2.5	32.9	32.4
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	2,561.8	2,520.8	-41.0	932.7	1,747.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	4.7	3.9	-0.8	1.3	2.2
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,425.7	-1,832.9	-407.2	-1,456.8	-1,587.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.6	-2.8	-0.2	-2.0	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	5,359.7	5,850.4	490.7	6,145.6	6,406.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	9.8	8.9	-0.9	8.4	8.1
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	35,434.5	39,276.0	3,841.5	43,704.0	47,610.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	65.0	60.0	-5.0	60.0	60.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	1,961.2	2,153.8	192.6	2,241.6	2,305.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.6	3.3	-0.3	3.1	2.9

Эх үүсвэр: Сангийн яам

Монгол Улсын 2023 оны төсвийн зарлагыг 20,475.3 тэрбум төгрөг, алдагдлыг 1,425.7 тэрбум төгрөг байхаар баталсан ч өнөөдөр цалин, тэтгэврийг нэмэх талаар яригдаж байна. Төсвийн алдагдал, төлбөрийн тэнцлийн алдагдал нь валютын ханш, инфляцад нөлөөлөх бөгөөд энэ нь цаашлаад иргэдийн бодит цалин, гадаад зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт ч сөргөөр нөлөөлсөөр олон жил болж байна. Иймд энэхүү гинжин хэлхээг тасалж эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулах зайлшгүй шаардлагатай юм. Үүний тулд 2024 оны төсвийг алдагдалгүй байхаар төлөвлөх нь зүйтэй.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тооцооллоос харахад 2024 оны ДНБ-д эзлэх нийт зардал дараагийн жилүүдээс харьцангуй өндөр түвшинд тооцогдсоныг дурдах нь зүйтэй.

Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс УИХ-ын гишүүдэд хүргүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд хийсэн шинжилгээ, дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хэлэлцэж, дэмжсэн болно.

--oOo--



Хавсралт 1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага төрлөөр

Үзүүлэлт/Огноо	Төрөл	2017	2018	2019	2020	2021
<b>НИЙТ</b>	<b>Орлого</b>	<b>1,546.3</b>	<b>1,902.6</b>	<b>1,879.5</b>	<b>1,878.2</b>	<b>2,732.</b>
	<b>Зарлага</b>	<b>1,890.9</b>	<b>2,122.8</b>	<b>2,062.3</b>	<b>2,451.8</b>	<b>2,565.6</b>
Тэтгэврийн даатгалын сангийн	Орлого	880.3	1,139.4	1,469.5	1,595.4	2,360.7
	Зарлага	1,417.4	1,619.3	1,839.2	2,174.9	2,300.6
Тэтгэмжийн даатгалын сангийн	Орлого	112.7	128.5	157.5	111.4	180.1
	Зарлага	100.2	113.8	126.2	147.7	172.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	Орлого	366.4	422.3	0.	0.	0.
	Зарлага	292.2	308.2	0.	0.	0.
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	Орлого	147.8	171.2	211.	145.5	129.2
	Зарлага	46.	46.8	52.9	34.2	34.4
Ажилгүйдлийн даатгалын сангийн	Орлого	39.	41.1	41.5	25.9	61.9
	Зарлага	35.1	34.7	44.	94.9	57.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

#### **Хавсралт 4. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд өгсөн зөвлөмж**

2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай төсөлтэй Төсвийн тогтвортой байдлын зөвлөл танилцаад УИХ-ын 2017 оны 83 дугаар тогтоолоор баталсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийн 3.1.1 дэх заалтад тусгагдсан бүрэн эрхийн хүрээнд дор дурдсан зөвлөмжийг гаргаж байна.

2023 онд нүүрсний экспорт 45 сая тонн, ирэх онд 50 сая тоннд хүрч, улмаар эдийн засаг 2023 онд 6 хувь, 2024 онд 6.5 хувь өсөх төлөвийг боловсруулсан байна. БНХАУ хилийн хязгаарлалтаа зөөлрүүлж, манай улсын нүүрсний экспорт 1 дүгээр улиралд огцом сайжраад байгаа хэдий ч одоогийн байдлаар БНХАУ-д нүүрсний нөөцийн хэмжээ сүүлийн 3 жилийн дээд хэмжээндээ хүрсний зэрэгцээ тус улс 2022 онд нийтдээ 63.8 сая тонн коксжих нүүрс бусад орнуудаас импортлосон байна. Иймээс Монгол улсын экспортлох хүчин чадлаас гадна худалдан авагч орны эрэлт, сонирхлыг харгалзан үзэх нь чухал юм. Мөн БНХАУ-д нүүрсний татан авалт, нөөц нэмэгдсэнтэй холбоотой нүүрсний үнэ буурах төлөв ажиглагдаж байна. Энэ нь манай улсад бодит эрсдэлийг дагуулж байна. Өөрөөр хэлбэл өөдрөг орлогын төсөөлөлд суурилсан мөчлөг дагасан төсвийн бодлого хэрэгжүүлэх суурь нөхцөл болох эрсдэлтэй.

Иймд дунд, урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө, түүнтэй уялдсан хөрөнгө оруулалтын төслүүдийг ач холбогдол, эдийн засгийн үр ашгаар эрэмбэлж шат дараатай гүйцэтгэх хэрэгжүүлэх нь үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжийг олгоно. Олон төслүүдийг нэгэн зэрэг жил дамнан бүтээн байгуулах бус цөөн тооны туйлын ач холбогдолтой төслүүдэд илүү ач холбогдол өгч богино хугацаанд эдийн засгийн эргэлтэд оруулахад анхаарах нь тухайн төслийн өртөг жил бүр өсөх, үйлдвэрлэлийн явц удааширч алдагдсан боломжийн өртөг нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөг бууруулах боломжтой юм.

Монгол улс хөгжиж буй орны хувьд ДНБ-ийхээ 5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төсвийн хөрөнгө оруулалтын зардалд зориулж, түүнийхээ 60 орчим хувийг эдийн засгийн бодит салбарыг дэмжих, түүний дэд бүтцийг бүрдүүлэхэд зориулж байх алтан дүрмийг өнөөгийн байгалийн баялгаа ихээр ашиглах үед тогтоовол зохино гэж үзэж байна. 2023-2024 оны хувьд өмнийн говийн төмөр замыг Хятадтай холбох, эрчим хүчний үйлдвэрлэлийг наад зах нь 20 хувиар нэмэгдүүлж чадсан эсэхээр Засгийн газрын ажил, Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд дүгнэлт өгөх нь төлөвлөгөөний үндэс болно.

#### **ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ**

1. 2022 онд манай улсын төмөр замын сүлжээний урт 2,964.9 км болж 40 хувиар нэмэгдэв. Тавантолгой-Гашуунсухайт, Зүүнбаян-Ханги, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 876.4 км төмөр замын бүтээн байгуулалтын барилгын ажил дуусаж, төмөр замаар хийх экспортын гурван гарцтай болсон. Гэхдээ хил холболтын төмөр замын ажил хийгдээгүйн улмаас шинэ төмөр замын гарцуудаа бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна. Иймд эдгээр мухар төмөр замуудыг Бүгд найрамдах Хятад улсын төмөр замтай яаралтай 2024 онд багтаан холбож байж бид нүүрсний экспортоо нэмэгдүүлж, үнэтэй борлуулах боломж бүрдэнэ.

Цаашид аливаа бүтээн байгуулалтын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах нь эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх суурь нөхцөл болно. Иймээс өндөр өртөг бүхий ижил төстэй төслүүдийг нэг дор эхлүүлэх бус ач холбогдлоор эрэмбэлэн бүтээн

байгуулалтын ажлыг бүрэн гүйцэтгэж, үйл ажиллагаа нь жигдэрсний дараа шат дараатай хүчин чадлыг нэмэгдүүлж, төрөлжүүлэх нь төсөв болон валютын нөөцөд ирэх ачааллыг бууруулах, дотоодын нөөцийн хүчин чадлыг зохистой ашиглах зэрэг эерэг үр дагавартай.

2. Монгол Улсын цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээ 2022 онд 10.3 тэрбум кВт.ц болж өмнөх оноос 5.8 хувиар буюу 564.3 сая кВт.ц-аар нэмэгдсэн байна. Нийт хэрэглээний 79.1 хувийг буюу 8.18 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүчийг дотоодын үйлдвэрлэлээр, 20.9 хувийг буюу 2.16 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүчийг импортоор авч хангажээ. Импортын эрчим хүчний төлбөрт 182.3 сая ам.доллар зарцуулсан бөгөөд энэ нь өмнөх оны гүйцэтгэл 160.2 сая ам.доллараас 22 сая ам.доллар буюу 13.8 хувиар өссөн үзүүлэлт юм. Хэдийгээр Монгол Улсын Засгийн газраас Газраас цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлж байгаа ч энэ нь хэрэглээний өсөлтөөс давахгүй байгааг доорх хүснэгтэд үзүүлэв. Иймд Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Эрчим хүчний зорилт болон хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийг сайжруулж 2024 онд эрчим хүчний хүчин чадлыг доод тал нь 20-оос доошгүй хувиар нэмэгдүүлэх шаардлагатай байна.

*Хүснэгт 1. Цахилгаан эрчим хүчний импорт /сая ам.доллаар/*

Он	Нэгж	Тоо	Үнэ / Amount
2021	мян.квт.ц	1,823,077.9	160.2
2022	мян.квт.ц	2,107,367.6	182.3

*Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар*

Цахилгаан эрчим хүчний импортын хэрэглээ нь олон жил үргэлжилж, ялангуяа говийн үйлдвэрийн бүсүүдэд эрчим хүчний эх үүсвэр нэн шаардлагатай байгаа ч төсөл хөтөлбөрийн хэрэгжилт удааширсан хэвээр байна. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд хэд хэдэн эрчим хүчний төслүүд, өргөтгөлийн ажлуудыг тусгасан байгаа хэдий ч ойрын хугацаанд ашиглалтад орох томоохон хүчин чадал бүхий эрчим хүчний үйлдвэрүүд байхгүй байна. Түүнчлэн, эрчим хүчний салбарт олгож буй татаасын өгөөж тэгш бус байдгаас гадна эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлж, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөтэй байдаг. Суурь салбарын үнийг барьж, хөрөнгө оруулалтын сонирхлыг бууруулдаг гажиг тогтолцооноос салж, үнэ тариф, цалин хөлсний томоохон өөрчлөлт энэ салбарт хэрэгтэй.

Олон улсад сүүлийн жилүүдэд нүүрсний дулаан, цахилгааны станцуудаас татгалзаж байгаа ч гэсэн Монголын хувьд нүүрсээ ашиглахаас өөр аргагүй, үндэсний эрх ашигт нийцнэ гэж үзэж байна. Сүүлийн үед Герман зэрэг орнууд эргээд нүүрсээ эрчимтэй ашиглаж, технологио сайжруулах арга хэмжээ авч байна.

Улс орнууд сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэхэд төрөл бүрийн бодлогын арга хэмжээ, санаачилгуудыг дэмжин ажиллацгааж байна. Иймд, дэлхий нийтээр хүлэмжийн хийг бууруулах зорилтыг хангах хүрээнд нүүрстөрөгчийн үнийн (carbon pricing) тооцоог хийх, дунд, урт хугацааны бодлогодоо тусгаж нүүрстөрөгчийн үнийг алгуур нэвтрүүлэх бодлогыг тодорхойлох шаардлагатай тул жил бүрийн хөгжлийн төлөвлөгөөнд үе шаттайгаар тусгах нь чухал юм.

Үүний зэрэгцээ хувийн болон өрхийн хөрөнгө оруулалтыг ногоон эрчим хүч үйлдвэрлэхэд таатай нөхцөл бүрдүүлэх замаар дэмжих нь төсвийн алдагдлыг бууруулах, эрчим хүчний төвлөрсөн бус үр ашигтай тогтолцоог бүрдүүлэхэд ихээхэн хөшүүрэг болохоос гадна хүлэмжийн хийг бууруулахад хамгийн гол нөлөөг үзүүлнэ.

Нөгөө талд, төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авалтыг ногоон, тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцүүлэх, шийдвэр гаргалтад харгалзаж үздэг тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна. Ингэснээр төсвийн хөрөнгө оруулалтын өгөөж, үр ашгийг урт хугацаанд нэмэгдүүлэхээс гадна хүлэмжийн хийг бууруулах, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад чухал ач холбогдолтой юм. Яваандаа олон улсын жишгийн дагуу тендерээс татгалзаж, захиалагчийн хариуцлагыг нэмэгдүүлж, хамгийн сайн нийлүүлэгчийг сонгодог болох нь зүйтэй.

3. Төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг шийдвэрлэхдээ жижиг сум, суурины барилга барих, зам хашлага солих гэх мэтээс илүүтэйгээр Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд эдийн засгийн тэлэлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг шийдвэрлэхэд тэргүүн зэргийн ач холбогдол өгөх нь зүйтэй

4. Автозамын төслүүдийг эдийн засгийн өгөөж, бүс нутгийн онцлогт тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тээвэр, ачаа эргэлт, үйлдвэрлэлийн бүсийн гол замуудыг тэргүүн зорилт болгож онцлогт нь тохирсон чанартай зам барих нь урт хугацаандаа тээврийн зардлыг бууруулах, замын арчилгааны зардлыг багасгах, цаашлаад олон улсын транзит тээврийг хөгжүүлэх зэргээр дунд, урт хугацааны Монгол улсын хөгжлийн бодлоготой уялдуулах боломжтой юм. Тухайлбал, Замын-Үүд Улаанбаатар чиглэлийн авто зам нь Монгол улсын тээвэр, логистикийн гол хэсэг бөгөөд замын даацаас шалтгаалсан тээврийн хэрэгслийн жингийн хязгаарлалт нь энэ бүсээр дамжиж буй бүхий л бараа бүтээгдэхүүнд өртөг болон шингэж байна. Тиймээс зорчигч, ачаа тээвэр харьцангуй бага замуудыг шинээр барих, өргөтгөх ажлуудыг хойш тавьж эдийн засгийн өндөр үр өгөөжтэй, үйлдвэрлэлийн бүсүүдийг хөгжүүлэхэд дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг чиглүүлэх нь чухал байна.

5. Махны нөөц бүрдүүлэх, зарим нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор жил бүр хөнгөлөлттэй зээл олгож байгаа хэдий ч үр дүн муутай, улирлын шинж чанартай нийлүүлэлт доголдож, үнэ хэлбэлздэг хэвээр байна. Иймээс олон улсын сайн жишигтэй нийцтэй нийлүүлэлтийн гинжин сүлжээ, түүнд шаардлагатай дэд бүтэц, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд илүүтэй анхаарах нь хөгжлийн бодлогын чухал хэсэг юм. Иймээс хөнгөлөлттэй зээлээр түр зуур аргацаасан арга хэмжээ авахаас илүүтэйгээр зах зээлийн зарчимд суурилсан тогтвортой нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход анхаарах шаардлагатай байна.

6. Хүний хөгжлийн суурь болсон боловсрол, эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлсэн нь тодорхой дэвшил боллоо. Гэхдээ Монгол улсаас гадаадад эмчлүүлж буй иргэдийн зардал, боловсролын зардал, аяллын зардал, тээврийн зардал зэрэг нь жил бүр тасралтгүй нэмэгдэж байгаагаас үзэхэд эдгээр салбаруудад онцгой анхаарал хандуулж дотоодын хүчин чадал, чанарыг сайжруулах зайлшгүй шаардлага үүсээд байна. Иймээс судалгаанд суурилсан, орчин үеийн дэвшилтэт технологи, арга зүйг нэвтрүүлж хүний нөөцийг бэлдэх, шаардлагатай тохиолдолд гаднын нарийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах зэргээр дотоодод чадавхыг өргөтгөхөд хөрөнгө оруулалтыг чиглүүлэх нь дунд, урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцтэй, эдийн засгийн зорилтуудыг шийдвэрлэхэд дэмжлэг болохоор байна.

7. Хөгжлийн төлөвлөгөөнд татварын тогтолцооны талаар огт тусгагдаагүй байгаагийн зэрэгцээ цаашид анхаарах, бодлогын суурь судалгааг хийж эхлэх шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал, татварын бодлогоор орлогын тэгш бус байдлыг бууруулах, эдийн засгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, салбаруудын тэнцвэртэй болон тогтвортой хөгжлийг хөшүүргэдэх дунд хугацааны бодлогыг эхлүүлэхэд анхаарч эхлэх шаардлагатай.

## **Хавсралт 5. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс төсвийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал**

1. Төсвийн тухай хуульд (ТТХ) нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад ТТБЗ-ийн чиг үүрэг, статусыг хэрхэн өөрчлөх талаар тодорхой тусгагдаагүй байгаа тул ойлгомжгүй байдалтай байна. Иймээс ТТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг боловсруулсан хүмүүстэй ТТБЗ-ийн дарга, гишүүд уулзаж, хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн үндэслэлийн талаар ярилцах хэрэгтэй. Тухайлбал, ТБХ-ны ахлах зөвлөх Алтанзул, хуулийн төслийг боловсруулсан Мөнхзэсэм нартай уулзах.
2. ТТБЗ-ийн үүрэгт Засгийн газрын бүтцийн институцийн гүйцэтгэх үүрэгтэй давхацсан үүргийг оруулж, “8.1.1<sup>1</sup>.Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалын тооцоог хийж, жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн болон эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэсэн заалтыг өөрчилж томьёолох шаардлагатай. Учир нь ТТБЗ-өөс Засгийн газрын бүтцийн байгууллагуудад буюу СЯ болон ЭЗХЯ-нд энэ тооцооллыг хийж өгөх нь УИХ-ын ТБХ-ны дэргэд ажиллаж буй тус зөвлөлийн хараат бус байдал болон чадавхтай ч уялдахгүй юм. Иймээс “төсвийн тусгай шаардлагыг мөрдөхтэй холбоотой үндсэн үзүүлэлтүүд” гэж өөрчилж найруулах нь зүйтэй болов уу.
3. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (ТТБТХ)-ийн 16<sup>1</sup>.2-т “Зөвлөл нь 7 гишүүнээс бүрдэх бөгөөд Төсвийн байнгын хороо хариуцсан ажлын албанаас, Төсвийн байнгын хороо энэ хуульд заасан журмын дагуу томилж, чөлөөлнө” гэжээ. Гишүүдийн тоог 7 болгож цөөрүүлэх үндэслэлийг тодорхой болгох шаардлагатай. Мөн бүх гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтаар хүн нэг бүрээр шалгаруулах болсонтой санал нийлэхгүй байна. Одоогийн хуулиар УИХ, ЗГ, Монголбанкнаас тус бүр 2 төлөөлөл буюу санхүү, төсвийн чиглэлээр өндөр албан тушаал хашиж байсан туршлагатай хүмүүсийг ТТБЗ-д оруулдаг байсныг шууд халах нь зохисгүй гэж үзэж байна. Иймээс эдгээр 3 байгууллагаас дор хаяж нэг, нэг төлөөллийг нэр дэвшүүлж Зөвлөлийн гишүүнээр ажиллуулж, үлдэх 4 төлөөллийг нээлттэй сонгон шалгаруулдаг байхыг санал болгомоор байна.
4. Зөвлөлийн дарга, гишүүдийг томилох хугацаа 4 жил байгааг ТТБЗ-ийн дүрмээс хасаагүй хэрнээ ТТБТХ-д “16<sup>1</sup>.7.Зөвлөлийн гишүүд нь даргаа олонхын саналаар 2 жилийн хугацаагаар сонгож, чөлөөлнө. Зөвлөлийн даргыг нэг удаа улируулан сонгож болно” гэж тусгахаар санал болгосон нь зөрчилтэй байна.
5. Мөн 16<sup>1</sup>.4.4.ажлын хэсэг сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаар сонсгол зохион байгуулж хамгийн өндөр үнэлэмж авсан иргэнийг Зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж томилох саналаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ гэжээ. Энд өндөр үнэлэмж гэхээс илүү “өндөр үнэлгээ” гэж өөрчлөх нь зөв байх.

Үүнээс гадна ТТБЗ-тэй холбоотой холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус зөвлөлийн дарга Д.Даваасамбуу, гишүүн Э.Бямбажав нарыг оруулах саналтай байна.

## Хавсралт 6. Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголд өгсөн зөвлөмж

2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

**Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, Монгол улсын эдийн засагт учирч болох эрсдэл:** Цар тахлын сөрөг нөлөөлөл болон ОХУ-Украины дайнаас үүдэлтэй өндөр инфляцын эсрэг хэрэгжүүлсэн мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр дэлхийн эдийн засаг тогтворгүй байдалд байсаар байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт энэ оны хоёрдугаар хагаст мэдэгдэхүйц удааширч, 2024 онд эмзэг байдал үргэлжлэх төлөвтэй байна.

Банкны салбарын хямрал өргөжих, инфляцаас үүдэлтэй мөнгөний хатуу бодлогыг удаан үргэлжлүүлэх зэрэг нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг улам удаашруулж болзошгүй байна. Дэлхий дахинаа мөнгөний үнэ өсөж, өндөр хүүтэй болж байна.

Энэ нь дэлхийн эдийн засгийн өсөлт, гадаад эрэлтэд сөргөөр нөлөөлж, бүс нутгийн худалдаа, үйл ажиллагааг улам сааруулж болох бөгөөд хөрөнгийн урсгалыг бууруулж, валютын ханшийн уналтад хүргэж болно.

Ялангуяа гадаад зээлээс ихээхэн хамааралтай, гадаад өр ихтэй Монгол Улсын хувьд эрсдэл ихтэй байж болзошгүйг Дэлхийн банк онцолжээ. Хөрөнгийн дотогшлох урсгал удаашралтай байгаа үед мөнгөний ханшийн уналт нь дотоодын инфляцад нэмэлт түлхэц өгч, төв банкнаас бодлогын хүүгээ өсгөхөд хүргэж, энэ нь өсөлтийг сааруулахад нөлөөлж болох юм. Экспортын орлогын нэлээдгүй хувийг хөрөнгө оруулалтын буцалт, зээлийн хүү ногдол ашиг зэрэгт жилд дунджаар 2.2 тэрбум ам.доллар, гадаад худалдааны тээвэрт 2022 онд 1.4 тэрбум ам.доллар, төрөл бүрийн техникийн туслалцаа үйлчилгээнд 1.1 тэрбум ам.доллар, гадаад аялал оюутны төлбөрт 0.8 тэрбум ам.долларын зэрэг төлбөрт зориулагдаж, эдийн засаг, төсөв, хүн амын амьжиргааг дордуулж буй гол **нууц хүчин зүйлсийн** нэг болж байна. Иймд гадаадын хөрөнгө оруулалтын бодлогод ухаалаг өөрчлөлт хэрэгтэй болно.

Дэлхийн банкнаас бараа бүтээгдэхүүн экспортлогч хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтийг 2023 онд 1.9 хувь, 2024 онд 2.8 хувь, 2025 онд 2.9 хувь байхаар тооцсон бол Монгол Улсын Сангийн яамнаас 2023 онд 6.0 хувь, 2024 онд 6.5 хувь, 2025 онд 6.5 хувь байхаар тус тус тооцсон байна.

*Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт (улсаар)*

Эдийн засгийн өсөлт	2020	2021	2022e	2023f	2024f	2025f
<b>Дэлхийн эдийн засаг</b>	<b>-3.1</b>	<b>6.0</b>	<b>3.1</b>	<b>2.1</b>	<b>2.4</b>	<b>3.0</b>
<b>Хөгжингүй орнууд</b>	<b>-4.3</b>	<b>5.4</b>	<b>2.6</b>	<b>0.7</b>	<b>1.2</b>	<b>2.2</b>
АНУ	-2.8	5.9	2.1	1.1	0.8	2.3
Евро бүс	-6.1	5.4	3.5	0.4	1.3	2.3
Япон	-4.3	2.2	1.0	0.8	0.7	0.6
<b>Хөгжиж буй орнууд</b>	<b>-1.5</b>	<b>6.9</b>	<b>3.7</b>	<b>4.0</b>	<b>3.9</b>	<b>4.0</b>
Хятад	2.2	8.4	3.0	5.6	4.6	4.4
ОХУ	-2.7	5.6	-2.1	-0.2	1.2	0.8
Хятадаас бусад хөгжиж буй орнууд	-3.8	5.9	4.1	2.9	3.4	3.8
Бараа бүтээгдэхүүн экспортлогч хөгжиж буй орнууд	-3.7	5.1	3.2	1.9	2.8	2.9
Бараа бүтээгдэхүүн импортлогч хөгжиж буй орнууд	-0.3	7.9	3.9	5.0	4.4	4.5
Хятадаас бусад бараа бүтээгдэхүүн импортлогч хөгжиж буй орнууд	-4.0	7.0	5.3	4.2	4.2	4.8
<b>Монгол Улс (Засгийн газрын статистик ба тооцоолол)</b>	<b>-4.6</b>	<b>1.6</b>	<b>4.8</b>	<b>6.0</b>	<b>6.5</b>	<b>6.5</b>

*Эх сурвалж: Дэлхийн банк (2023.06)*

Төсвийн тодотголын төслийг боловсруулахдаа 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нэрлэсэн ДНБ-ий хэмжээ 60.2 их наяд төгрөг болж, эдийн засгийн бодит өсөлт 6.0 хувьд хүрнэ гэж тооцсон нь ДНБ-д эзлэх нэгдсэн төсвийн зарлагын дээд хэмжээ 2023 онд 37.2 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 34.5 хувь болж, тус бүр 0.4 нэгж хувиар буурна гэж тооцох үндэслэл болсон байна.

## **ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ**

Монгол Улсын эдийн засагт 2023 оны эхний саруудад гарч байгаа нааштай үзүүлэлт, түүнээс улбаалсан төсвийн орлогын өсөлт нь нийгмийн зарим асуудлыг шийдвэрлэх боломж олгож байна. Хүүхдийн мөнгийг бүх хүүхдэд олгох, тэтгэврийн зөрүүг багасгах улмаар нэмэгдүүлэх, цалинг нэмэгдүүлэхийг зарчмын хувьд дэмжиж байна. Эдгээр зардлыг нэмэгдүүлснээр жилд 4 их наяд орчим төгрөгийн нэмэлт зардал үүсэхээр байна. Энэ хэмжээний зардлыг дараагийн жилүүдийн эдийн засгийн өсөлт, төсвийн орлогоор хангах, төсвийн алдагдал, өрийн хэмжээг баримталж ажиллана гэдэг туйлын эргэлзээтэй байна. 2023 оны гол үр дүн нь энэ оны эхний саруудын нүүрсний экспортын өсөлтийг дагуулан жилдээ 50 сая тонн нүүрс экспортолно гэж төсөөлж байна. Үүнд нүүрсний хэмжээ болон үнийн эрсдэл гарахаар байна. Нөгөө талаар жилд 4 их наяд төгрөгийн байнгын зардал нэмэгдэхээр байгаа учир бусад төсвийн урсгал зардлыг танах шаардлага үүсэж байна. Иймд нийт зардлын өсөлтийн 50-аас доошгүй хувийг зардлын хэмнэлтээс санхүүжүүлэх стратеги бодлого барьж ажиллавал зохино.

### **I. Хүүхдийн мөнгийг бүх хүүхдэд олгох талаар:**

Хүүхдийн мөнгийг бүх хүүхдэд олгохын зэрэгцээ цаашдаа халамжийн хуулийн хүрээнд эмзэг бүлэгт нь олгох асуудлыг хэвээр нь үлдээх шаардлагатай. Хэрэв эдийн засаг хүндрэх тохиолдолд бүх хүүхдэд олгох бус зайлшгүй шаардлагатай хүүхдүүд олгох нөхцөлийг тооцох. Хүүхдийн мөнгийг ирээдүйн өв сангаас зарцуулахаар тооцсон бөгөөд Ирээдүйн өв сангийн мөнгийг хуримтлал болгож байх хуулийн заалттай. Иймд хүүхдийн мөнгийг бүхэлд нь мөнгөн хадгаламж хэлбэрээр хуримтлал болгож, түүнээс халамжийн хуулийн шаардлага, нөхцөлийн дагуу зарцуулах эрхийг нь эцэг эхэд нь үлдээх, хүүхдийн мөнгийг хуримтлал болгох бодлого барих шаардлагатай.

### **II. Тэтгэврийн зөрүүг багасгах, улмаар нэмэгдүүлэх талаар:**

Тэтгэврийн зөрүүг багасгаж, тэтгэврийг нэмэгдүүлэх чухал ч гэсэн цаашдаа тэтгэврийн сангийн дампуурах эрсдэлийг багасгах, дэлхий нийтийн сүүлийн үеийн хандлагад нийцсэн шинэчлэл хийх үүднээс тэтгэврийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх хөшүүрэг бий болгох, ахмадуудад тэтгэврийн нэмэгдэл орлого бүрдүүлэх тодорхой бодлого гаргах шаардлагатай. Үүний тулд өндөр насны тэтгэврийн даатгалаас даатгуулагчийн өөрийн төлж байгаа хэсгийг мөнгөн хадгаламж хэлбэрээр хуримтлал болгох нь зүйтэй юм.

### **III. Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого хэрэгжих амин сүнс нь урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэр**

Дээр дурдсан хүүхдийн мөнгө болон тэтгэврийн даатгалаас хуримтлал бий болсноор Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан томоохон төсөл, арга хэмжээнүүдийг дунд хугацаанд дотоодын эх үүсвэрээс санхүүжүүлэх боломж бүрдэж, гадаад эх үүсвэрийн хөрөнгө төсөв болон төлбөрийн тэнцэл дээр их ачаалал үүсгэж байгаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх давуу талтай юм. Мөн төсөв болон төлбөрийн тэнцэл дээр өндөр ачаалал үүсгэж байгаа зарим гадаадын хөрөнгө оруулалтыг бодлогын түвшинд эргэж харах шаардлагатай байна. Ажлын байр, нэмүү өртөг бий болгосон хөрөнгө оруулалтыг татвараас чөлөөлж, харин байгалийн баялгийг ухаж авдаг, эсвэл ууж идэх, наргиж наадах чиглэлийн үйл

ажиллагаа явуулдаг (баар цэнгээний газар, хоолны газар) салбарын хөрөнгө оруулалтад зарчмын өөрчлөлт хийх хэрэгтэй байна.

Хуримтлал үүсгэснээр Үндсэн хуулийн гол өөрчлөлт болсон баялгийн өгөөжийг өнөө ба ирээдүй үедээ тэгш хуваарилна гэсэн зарчимтай нийцэхийн зэрэгцээ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үндсэн зорилго болсон хуримтлал бий болгох гэсэн зарчимтай нийцэх юм. **Баялгаа эрчимтэй ашиглах үедээ эдийн засгийг алс ирээдүйдээ хөтлөгчөө одооноос олж бэлдэж авахгүй бол нөөц дуусах болно.**

#### **IV. Цалинг нэмэгдүүлэх талаар:**

1. Монгол Улсад ажилчин хүний хөдөлмөрийн **үнэлэмж** маш бага байгаа учир чадварлаг боловсон хүчин гадаад гарч улс орон чадварлаг болсон хүчнээр дутах эрсдэл их байна. Тийм учраас төрийн албан хаагчдын чадварлаг 10 хүртэлх хувьд нь цалинг тогтоосон хэмжээнээс нэмж олгох боломжийг төсвийн байгууллага болон улсын үйлдвэрийн газруудад хуулиар нээж өгөх. Энэ мөнгийг өөрийн орлого болон ноогдол ашгаас нь тооцож олгохоор журамлах, хуульчлах хэрэгтэй болно.
2. Цалинг нэмэгдүүлэхийг дэмжиж байгаа ч дараагийн жилүүдийн төсөвт зардал нь ямар дарамт учруулж, хэрхэн нөлөөлөх тооцооллыг хийж, үндэслэлийг тодорхой болгох.
3. Цахимжуулалтыг эрчимжүүлэх замаар төрийн албыг цомхотгож цөөн хүнээр бүтээмжтэй ажиллах. Тэгвэл төсвийн зардлыг нэмэлгүйгээр 1 төрийн албан хаагчийн цалинг нэмж чадна. Ингэж чадахгүй бол цаашид чөтгөрийн тойргоос гарч чадахгүй. Энэ олон бүтээмж муутай хүний цалинг дийлэхгүй. Цалинг өсгөж төрийн албанд сайн боловсон хүчнийг хадгалах боломж үүсэхгүй.
4. 2024 оны нэгдсэн төсвийн нийт зардлыг 2023 оны анх батлагдсан төсөвтэй харьцуулахад цалингийн зардлын өсөлтөд нь 2 их наяд орчим төгрөг, тэтгэвэр, халамжийн зардлын нэмэгдэлд 1.6 их наяд орчим төгрөг, хүүхдийн мөнгөнд 167.2 орчим тэрбум төгрөг, нэг удаагийн тэтгэмжид 207 орчим тэрбум төгрөг буюу нийт 4 гаруй их наяд төгрөгөөр төсвийн зардал нэмэгдэхээр байна. Эдгээр зардал нь байнгын зардал учир бусад зардал дээрээ хэмнэлт гаргах, зардал хэмнэх сонирхлыг урамшуулах, давхардсан орон тоог цөөрүүлэх, засаг захиргааны бүтцийг багасгах замаар зардлын ачааллыг бууруулах шаардлагатай байна.
5. Цалингийн өсөлт дунджаар 40 хувь гэдэг бол маш өндөр өсөлт. Тиймээс бага багаар, сэм сэмхэн зардалд шингээх байдлаар өсгөхгүй бол үнийн өсөлт болж, бодитоор нэмэгдэхгүй байх эрсдэлтэй.
6. Цаашид цалин, тэтгэврийн өсөлтийг хэрэгжүүлэхдээ зөрүүг тодорхой түвшинд хадгалж байхгүй бол шударга ёсны зарчим алдагдах, тэтгэврийн сан ачааллаа дийлэхгүй болох, тэтгэврийн санд хуримтлуулах сонирхол буурах зэрэг сөрөг үр дагаврууд үүснэ.
7. Цалинг шууд нэмэхээс илүүтэйгээр татвараас чөлөөлөгдөх орлогын босгыг нь нэмэгдүүлж болно.
8. Цалин, тэтгэврийг нэгэн цаг мөчид хавтгайруулж нэмэхгүй байх. Учир нь үнийн хөөргөдөл үүсгэнэ. Иймд цаг хугацааны зөрүүтэй байлгах, цалин тэтгэвэр нэмснээ бага сурталчлах, нарийн хугацааг заахгүй бүрхэг байдлаар дэс дараатай шийдэх, хүнсний хангамж, нийлүүлэлт дээд хэмжээнд хүрсэн үеийг ашиглах зэрэг арга хэрэгслүүдийг хэрэглэж, иргэдийн эрх ашгийг хамгаалах нь чухал болно.



## **V. Төсвийн хөрөнгө оруулалтын талаар:**

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг бууруулаагүй байгааг дэмжиж байна. Үүний зэрэгцээ төсөв, төлбөрийн тэнцлийн тогтвортой байдалд ноцтой нөлөө үзүүлж байгаа эрчим хүчний импорт болон төмөр замын хилийн боомт дахь холболтын асуудлыг яаралтай энэ онд багтаан шийдэх шаардлагатай байна. Учир нь Монгол Улс өндөр үнэтэй, их хэмжээний цахилгаан эрчим хүчийг гадаадаас авч татвар ноогдох орлогыг бууруулж байна. Мөн Таван толгойгоос Гашуун сухайт хүртэлх төмөр замын ажил удааширч байгаагаас авто замаар маш өндөр өртөгтэйгөөр тээвэр хийж байна. Иймд цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг 20-30 хувиар нэмэгдүүлэх, ялангуяа Бөөрөлжүүтийн цахилгаан станцыг дуусгах, Тавантолгойн цахилгаан станцыг эхлүүлсэн байх, төмөр замын хил орчмын холболт, ялангуяа Тавантолгой-Гашуун сухайтын төмөр замын боомтын холболтын бүтээн байгуулалтыг энэ ондоо багтааж дуусгахад улс төр, дипломатын хөрөнгө мөнгөний бүхий л хүчин чадлаа гаргах шаардлагатай байна. *Ганц энэ асуудлыг Боомтын сайдад хариуцуулж, үр дүнгээр хариуцлага тооцож болох юм.*

## **VI. Төсвийн тодотгол хийх нөхцөл бүрдсэн эсэх талаар:**

Төсвийн тухай хуулийн 34.1-д заасны дагуу Засгийн газар Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна. Гэхдээ ТТХ-ийн 34.1.1-34.1.5-д тусгагдсан төсвийн тодотгол хийх тохиолдлуудаас 34.1.4 дэх заалт буюу “төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” гэсэн үндэслэлийг сонгосон нь эрх зүйн талаасаа эргэлзээтэй байна.

УИХ-ын 2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 88 дугаар тогтоолын 6 дугаар заалтын дагуу Монгол Улсын 2023 оны төсвийг УИХ-аас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төлөвлөн хэрэгжүүлэхээр заасан боловч Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэлд 2 дахь удаагаа<sup>3</sup> өөрчлөлт оруулахаар өргөн мэдүүлж байгаа нь энэхүү заалтын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн тухайн жил бүрийн төсвийн төслийг төлөвлөн хэрэгжүүлэхгүй, тодотгол өөрчлөлт хийсээр байгаа нь төсвийн тогтвортой байдал, хариуцлага, сахилга бат алдагдах, улмаар төсвийн зардал нэмэгдэх, алдагдал буурахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

## **VII. ТТБТ хуулийн төсвийн тусгай шаардлагуудыг хангаж буй эсэх талаар:**

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 20,781.9 тэрбум төгрөг (ДНБ-ий 34.5 хувь), нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээ 22,371.4 тэрбум төгрөг (ДНБ-ий 37.2 хувь) байхаар тооцож, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,589.5 тэрбум төгрөг (ДНБ-ий 2.6 хувь)-тэй тэнцэх хэмжээний төсвийн алдагдалтай байхаар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тооцоолжээ.

УИХ-аар батлагдсан нэгдсэн төсвийн 2023 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан эдийн засгийн бүх үзүүлэлт өөрчлөгдсөн байна. Үүний дотор нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал болон өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдэл хоёулаа өсөхөөр байна. Эдийн засгийн бодит өсөлтийн хувь төлөвлөснөөс нэмэгдэж байгаа нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өсөх нөхцөлийг бүрдүүлж байна.

---

<sup>3</sup> МУ-ын нэгдсэн төсвийн 2023 оны ТХМ, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр баталж, 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулж баталсан.

*Хүснэгт 2. Монгол Улсын нэгдсэн төсөв*

Монгол Улсын Нэгдсэн төсөв	Нийт зардлын дүн	Өмнөх онтой харьцуулсан өсөлтийн хувь	2019 онтой харьцуулсан өсөлтийн хувь
2019 оны гүйцэтгэл	11,661,700.9		
2020 оны гүйцэтгэл	13,904,273.0	19.2%	19.2%
2021 оны гүйцэтгэл	15,630,443.9	12.4%	34.0%
2022 оны гүйцэтгэл	18,159,668.9	16.2%	55.7%
2023 оны батлагдсан төсөв	20,475,301.0	12.8%	75.6%
2023 оны тодотголын төсөл	22,371,353.9	23.2%	91.8%

*Эх сурвалж: Сангийн яам*

Тооцоолол нь төсвийн тусгай шаардлагуудыг хангаж байгаа хэдий ч зардлын өсөлтийн хувь нь өмнөх онуудтай харьцуулахад хэт өндөр, мөн байнгын шинжтэй зардал нэмэгдэж байгаа нь цаашид эрсдэл дагуулахаар байна. Иймд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд төсвийн зардлын өсөлтийн дээд хэмжээг тогтоож тусгах шаардлагатай гэж үзэж байна.

### **VIII. Төсвийн урсгал зардлыг танах талаар:**

1. Төсвөөс олгож байгаа бүх төрлийг татааснуудыг шинэчилж цаашдаа орлогоороо зардлаа нөхдөг байх зарчмыг баримтлахгүй бол жилээс жилд татаасын хэмжээ нэмэгдэхээр байна. Тухайлбал: Монгол Улсын нэгдсэн төсвөөс 2023 онд 1,136,568.3 сая төгрөг (хүснэгт 2)-ийн татаас олгохоор байгааг цаашид бодлогын түвшинд бууруулах шаардлагатай байна.

*Хүснэгт 3. Монгол Улсын нэгдсэн төсвөөс олгож буй татаас /зориулалтаар/, сая төгрөг*

	НЭГДСЭН ТӨСӨВ	УЛСЫН ТӨСӨВ	ОРОН НУТГИЙН ТӨСӨВ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН
<b>Татаасын зориулалт</b>	<b>1,136,568.3</b>	<b>967,756.5</b>	<b>78,829.4</b>	<b>89,982.5</b>
Нийтийн тээврийн алдагдал олгох татаас	76,161.7	0.0	76,161.7	0.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	110,432.8	109,518.5	914.3	0.0
ЭМД-ын сангаас санхүүжих эмийн үнийн хөнгөлөлт	89,982.5	0.0	0.0	89,982.5
Тэтгэврийн санд олгох татаас	774,367.1	774,367.1	0.0	0.0
Усан хангамжийн татаас	1,753.4	0.0	1,753.4	0.0
Түшиц эмнэлэгт олгох татаас	2,300.0	2,300.0	0.0	0.0
Тусгай эмнэлэгт олгох татаас	9,696.4	9,696.4	0.0	0.0
Эрчим хүчний алдагдлын татаас	71,874.5	71,874.5	0.0	0.0

*Эх сурвалж: Сангийн яам*

2. Нийслэлийн 2023 оны төсвийг 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 115 дугаар тогтоолоор баталсан бөгөөд үүнд нийслэлийн нийтийн тээврийн газарт 229.5 тэрбум төгрөг олгохоор тусгасан байна. Үүнээс гадна Нийслэлийн төсөвт Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн орон нутгийн зээллэгийн үндсэн болон хүүгийн төлбөр 7.7 тэрбум төгрөг, Улсын төсөвт нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр-1-ийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр 11.2 тэрбум төгрөг тусгасан байна.

*Хүснэгт 4. Нийтийн тээврийн газрын урсгал зардал, тэрбум төгрөг*

№	Нийтийн тээврийн газар	229.5
1	Нийтийн тээврийн газрын үйл ажиллагааны зардал	7.7
2	Цагдаагийн албан хаагчдад олгох нийтийн тээврийн нөхөн олговор	1.6
3	Оюутнуудад олгох нийтийн тээврийн унааны нөхөн олговор	5.1
4	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагчдад олгох нийтийн тээврийн унааны нөхөн олговор	1.3
5	Ахмад настай иргэдэд олгох нийтийн тээврийн унааны нөхөн олговор	23.0
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох нийтийн тээврийн унааны нөхөн олговор	9.6
7	Нийтийн тээврийн үйлчилгээний машин цагийн зардлын зөрүү, сургуулийн автобусны үйлчилгээний дэмжлэг	181.2

*Эх үүсвэр: Нийслэлийн 2022 оны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 115 дугаар тогтоол*

Иймд энэ салбарын үнийг чөлөөлж, өөрийн орлогоороо зардлаа нөхөх түвшинд хүргэх шаардлагатай байна.

3. Монгол Улс 2022 онд цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээнийхээ 20.9 хувийг буюу 2.16 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүчийг импортоор авч хангасан ба импортын эрчим хүчний төлбөрт 182.3 сая ам.доллар зарцуулсан байна. Энэ салбарын хөгжлийг хязгаарлахад үнийн хатуу бодлого, төрөөс өгч байгаа татаас (2023 онд эрчим хүчний алдагдалд 71,874.5 сая төгрөг) болон шууд бус татаас ихээхэн нөлөөлж байна. Иймд иргэдийн цалин, тэтгэвэр нэмэгдэж байгаа энэ үед айл өрхийн цахилгаан хэрэглээний тарифыг аж ахуй нэгж байгууллагуудын тарифтай ижил болгох, цаашид үнийг чөлөөлөх шат дараатай арга хэмжээ авч энэ салбарыг хөгжлийг бодлогоор дэмжих шаардлагатай байна. Цахилгааны үнэ тарифыг хавсралтад үзүүлэв.

## **IX. Төсвийн орлогын талаар:**

Монгол Улсын 2023 оны тэнцвэржүүлсэн орлого 20,781.9 тэрбум төгрөг буюу батлагдсан дүнгээс 1,732.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр төсвийн тодотголд тусгасан нь татварын орлогыг 1,722.3 тэрбум төгрөгөөр өснө гэж тооцсонтой холбоотой байна. Энэхүү орлогын өсөлтийн 44.5 хувийг хувь хүний болон аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар (хувь хүний орлогын албан татвар 121.1 тэрбум, орлогын албан татвар 645.7 тэрбум төгрөг), 21.3 хувийг АМНАТ, 14.0 хувийг НӨАТ, 11.2 хувийг НДШ, хураамж, 7.2 хувийг гаалийн албан татварын орлогын өсөлтөөс бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Уул уурхай, гадаад ба дотоод худалдаа, тээвэр үйлчилгээний салбар болон нийгмийн даатгалаас орох орлого голлон өсөхөөр байна.

1. Төсвийн орлого 2023 оны эцэс гэхэд энэ хэмжээнд төвлөрөх нь баталгаатай эсэх, дараагийн жилүүдэд төсвийн тодотголд тооцсон хэмжээнээс буурахгүй байж, өсөн нэмэгдэж буй урсгал зардлыг санхүүжүүлж чадах эсэх нь тодорхойгүй байгааг анхаарах шаардлагатай байна.
2. Цалинг 7 болон 10 дугаар саруудад дэс дараатайгаар нэмэгдүүлэхэд 2023 онд 1 их наяд орчим төгрөг шаардлагатай байгаа нь 2024 онд жилийн дүнгээр 2 орчим их наяд төгрөгийн нэмэлт эх үүсвэр шаардлагатайг харуулж байна. Энэхүү эх үүсвэрийн голлох хэсгийг нүүрсний орлогоор бүрдүүлэхээр тооцоолж байгаа нь эрсдэлтэй байна. Иймд энэ орлогыг баталгаатай болгохын тулд бусад орнуудын адил БНХАУ-тай нүүрс нийлүүлэх гэрээг байгуулж орлогыг цаашид баталгаажуулах боломжийг эрэлхийлэх нь чухал байна.

## **Хавсралт 7. Төсвийн байнгын хорооны хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлээс**

*2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, Даваа гараг  
Төрийн ордон “Жанжсн Д.Сүхбаатар” танхим  
12 цаг 13 минут*

*Д.Даваасамбуу: Эрхэм Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг эрж мэндчилье. Юуны өмнө Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг Төсвийн байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр шийдсэн явдалд гүн талархалтай байна.*

*Миний бие цөөхөн зүйл дээр асуудлыг ярьж гэж бодож байна. Манай Төсвийн тогтвортой байдлын тухай хууль маань 2010 онд батлагдсан. Энэ хуулийн маань үндсэн үзэл баримтлал бол байгалийн баялгаа эрчимтэй ашиглах үедээ хуримтлал бий болгоно гэсэн ийм заалттай. Энэ хуримтлал бий болгоно гэсэн заалт нь манай Төсвийн тогтвортой байдлын хуулийн 1 дэх заалт. Хуримтлал бий болгох.*

*2 дугаарт, 2019 онд Монгол Улс Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулсан. Энэ хуулиар байгалийн баялгийн өгөөжийг өнөөгийн ба ирээдүй үедээ тэгш, тэнцвэртэй хуваарилна гэсэн ийм зарчим. Тэгээд эдгээрийг үндэслээд бид саналаа гаргасан.*

*Ингэхдээ бид төсвийн тогтвортой байдлыг хуулийг мөрдсөнөөс хойш Тогтворжуулалтын сан, Ирээдүй өв сан, Хүний хөгжлийн сан гэх олон төрлийн санг байгуулж, тодорхой үр дүнд хүрч байсан. Гэхдээ эдгээр сангуудыг бид өнөөдрийн байдлаар үндсэнд нь зарцуулдаг ийм эрх зүйн орчин бүрдүүлчхээд байгаа. Тухайлбал төсвийн тогтвортой байдлын санг төсвийн зардлыг төсвийн алдагдлыг нөхөж зарцуулна гэж хуульчилсан.*

*2 дугаарт, Ирээдүй өв сангийн мөнгийг 2 жилийн өмнөөс эхлээд Монгол Улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгож, Монгол Улсын Сангийн яамны сайдын багцад хуваарилж орлогыг нь өөрөө, орлогыг нь төсвийн бүрэлдэхүүн болгож, зардлыг нь мөн бас төсвийн бүрэлдэхүүн буюу хүүхдийн мөнгөнд хуваарилдаг ийм тогтолцоо бүрдсэн. Энэ юуг харуулж байна вэ гэхээр бид цаашидаа энэ 2 сангаар дамжуулж, нөгөө бидний Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үндсэн зорилт болсон хуримтлалыг хэрэгжүүлэхэд хүндрэл учрах нь ээ гэсэн ийм ойлголттой байгаа.*

*Тийм учраас бид энэ төсвийн тогтвортой байдлын хуулийнхаа үндсэн үзэл баримтлал буюу хуримтлал бий болгох, ялангуяа байгалийн баялгийг эрчимтэй ашиглаж байгаа өнөөгийн үе ялангуяа энэ нүүрс, 2 жилийн дараагаас хамгийн эрчимтэй ашиглах зэс зэрэг баялгийг ашиглаж байгаа энэ өнөө үед төсвийг Монгол Улсад хуримтлал бий болгох явдал нэн чухал болжээ.*

*Дээрээс нь Монгол Улсын хөгжлийг 50 он хүртэл хөгжүүлэх зорилт, сэргээх томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд урт хугацаатай хөрөнгийн эх үүсвэрүүд шаардлагатай байгаа. Энэ бүхнийг бодолцоод дэлхий нийтийн жишиг буюу нийгмийн даатгалын системээр дамжуулж хуримтлал бий болгодог системийг Монголд бүрдүүлэх нь зүйтэй гэсэн саналд хүрсэн байгаа. Тухайлбал НДШ-ээс өндөр настны шимтгэл төлөгддөг хувь хүнийх, ажил олгогчдын хэсгээс хувь хүний төлдгийг шууд дансанд нь олгоё. Өөрөөр хэлэх юм бол 2,4 их наяд төгрөгийн тэтгэврийн сангийн тал орчим хувь нь буюу 1,3 их наяд төгрөг нь хувь хүмүүсийн НДШ болж, цаашидаа хуримтлал болно.*

**Ингэхгүйгээр бид хүмүүсээ даатгалд хамаарагддаг сонирхлыг бүрдүүлж чадахгүй. Нөгөө талаас даатгалын хамралт улам бүр багасаад байх ийм төлөв ажиглагдаж байна.**

Дээрээс нь байгалийн баялаг бүхий орнууд бүгд энэ хэлбэрт хүрсэн, ийм хэлбэртэй болсон. Жишээлбэл Австрали албан журмын даатгалтай, бид ойрхон хөршөө харъя. Бүгд Найрамдах Хятад Ард Улс бол нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчийнх нь төсөвтөө авч, даатгалынхаа санд авч, суурь тэтгэврийг шийдвэрлэж байгаа. Хувь хүмүүсийнх нь бол өөрийнх нь дансанд хадгаламж хэлбэрээр ашиглаж байгаа. Энэ олон улсын жишиг бол үндсэндээ хориод жилийн өмнөөс эхэлсэн бөгөөд өнөөдөр бид бараг сүүл мушгих гэх хэлбэр лүү орж байна. Тийм учраас энэ хуримтлалын систем рүү шилжихгүйгээр энэ нийгмийн даатгал болон төсвийг цаашид эрүүлжүүлэхэд нэлээн хүндрэл учирна гэж үзэж байгаа.

**Нөгөө талаасаа бид баялгаа нэн эрчимтэй ашиглаж байгаа үед сэргээгдэх хуримтлалтай болно гэдэг хуульдаа заачихсан юм. Сэргээгдэх эх үүсвэртэй болно гэж. Өөрөөр хэлэх юм бол Оюутолгой, Тавантолгойн ашиглалт 30 жилийн дараа багаслаа гэж үзвэл үүнээс үүссэн нийгмийн даатгалын хуримтлал буюу нэг 50-60 их наяд төгрөг маань өөрөө Монгол Улсыг цааш нь хөтлөөд явах хөгжлийн гол хөшүүрэг болно гэсэн концепцын үүднээс ярьж байна.**

Тийм учраас бид цаашидаа төсвийн алдагдлыг буюу нийгмийн даатгалын шимтгэлийн алдагдал буюу өндөр насны тэтгэврийн хувь хүмүүсээс гарч байгаа хэмжээнд нь барьж, хувь хүмүүст нь нийгмийн даатгалын шимтгэлийн дансанд оруулъя. Чингэхдээ бид 5 жилийн дараагаас хүмүүст сонголтыг нь өгье. Эхний 5 жилдээ хүмүүс Монгол Улсын системн ач холбогдолтой банкнуудыг сонгуулъя. Тэгээд 5 жилийн дараа сонголттойгоор тэтгэврийн хадгаламжаа байршуулж байя, 5 жилийн дараагаас хөрөнгийн зах зээл буюу хувьцаа, хөрөнгө оруулалтын санд олгодог системийг тогтоож өгье. Энэ хүртэл бид холбогдох хууль, дүрэм, журмыг нь тогтооё гэсэн ийм агуулгатайгаар явъя гэж үзсэн.

Цаашидаа 20 жилийн дотор өнөөдрийн Ирээдүй өв сан болон Тогтвортой хөгжлийн тогтворжуулалтын сангийн орлогоороо энэ нийгмийн даатгалынхаа алдагдлыг цэгцлээд суурь тэтгэврийнхээ систем рүү 15-20 жилийн дараа орчихно гэсэн ийм тооцоо судалгаанууд хийгдсэн байгаа. Энэ маань өөрөө бид нар энэ төрийн мэдэлд байдаг сангаа хувь хүмүүсийн мэдэлд өгч зарцуулах, ингэснээр Монгол Улсад цаашидаа урт хугацаанд хөрөнгийн эх үүсвэр бий болох, ялангуяа томоохон хэмжээнд төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх эх үүсвэр бүрдэнэ гэсэн ойлголттой. Энэ маань өөрөө дэлхий нийтийн жишиг гэж ойлгож байгаа.

Бид өнөөдөр энэ даатгалын системтэй Америк гэхэд ухаан нь Америкийн хуримтлал нь дотоодынхоо нийт бүтээгдэхүүний 130.0 хувьтай тэнцэж байна. Хятадынх НДШ нь хувь хүмүүсийнх нь шимтгэл өгдөг өөрсдийнх нь дансанд ордог учраас далд эдийн засгийг бол үндсэнд нь байхгүй болгосон. Хүн бүхэн ажил л хийж байвал, даатгалынхаа мөнгийг өөртөө авах ийм сонирхолтой болсон. Энэ маань маш олон төрлийн ач холбогдолтой шүү. Ялангуяа өнөөгийн нөхцөлд энэ далд эдийн засгийг илрүүлж засах үндсэн арга НДШ-ийг хувь хүмүүсийнх нь дансан дээр өгөх явдал гэж ойлгож ийм санал оруулж байгаа.

*Бусад саналуудын хувьд манай Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Бямбажав гуай ярина гэж та бүгдэд танилцуулна. Ингээд анхаарал тавьсанд баярлалаа. Бид танилцуулгаа тараачихсан, илтгэлээ слайдаар бэлдчихсэн байгаа бас тараачихъя. Би зүгээр товчлоод ярьчихлаа шүү, дарга нар аа, уучлаарай. Баярлалаа.*

**Г.Тэмүүжин:** *Даваасамбуу даргад баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Батсуурь гишүүнээр тасаллаа. Тогтохсүрэн гишүүн.*

**Д.Тогтохсүрэн:** *Баярлалаа. 2024 оны төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэж байна, 24 он ямар байх вэ гэдэг. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс бас тодорхой хэмжээний зөвлөмж өгсөн байна. Би ингээд нэг 3, 4 асуулт асууя гэж бодож байна. 3 дахь асуудал бол сая Даваасамбуу гуайн илтгэлд их тодорхой дурдаж байгаа асуудал байгаа юм. Энэ хуримтлал бий болгох асуудал байгаа юм. Бид нар ингээд л өнөөдөр зах зээл дээр нүүрсний үнэ гайгүй байна, зэсийн үнэ гайгүй байна, төмрийн хүдрийн үнэ гайгүй байна, алтны үнэ гайгүй байна. Гэтэл бид нар хуримтлал бий болгож чадахгүй ингээд л гаргаад л идэж уугаад байгаа юм. 24 онд ер нь хуримтлал бий болгох чиглэлээр энэ төсвийн хүрээний мэдэгдэлд тодорхой туссан асуудал байна уу? Ер нь бид нар хуримтлалыг бий болгож байгаад л энэ хуримтлалаас явах, ер нь Ирээдүйн өв сан бол хуримтлал байсан. Тэгээд төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгоод төсөвт өгөөд, хүүхдийн мөнгөнд өгөөд ингээд явчхаж байгаа юм. Тэгэхээр энэ хуримтлалын асуудлыг би тодруулж 3 дугаарт нь асууя гэж бодож байгаа юм.*

*4 дүгээрт нь гадаад өртэй холбоотой асуудал байгаа юм. 33 тэрбум долларын өр байна, улсын өр. Үүний Засгийн газрын өр нь 8 тэрбум доллар байна. Мэдээж Засгийн газрын өрөө бол эрсдэлгүй явж байгаа, үүнийг бол ойлгож байгаа. Гэхдээ хани өсөөд байгаа, хани өсөхөөр манай төсөв дээр ирэх ачаалал нэмэгдэж байгаа. Цаашидаа төлөх бидэнд ачаалал үүсэж байгаа. Тэгэхээр 24 онд ямар хэмжээний өрийг төлөхөөр байна.*

**Г.Тэмүүлэн:** *Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Шадар сайд Хүрэлбаатар.*

**Ч.Хүрэлбаатар:** *Инфляцын талаар хуримтлал, өрийн тухай хариулъя. 2022 онд бол валютын хани 2844-3540 болоод 22 хувиар уналаа. Энэ нь эргээд бас инфляцад бол тодорхой хэмжээний нөлөө үзүүлсэн. Одоо бол валютын нөөц нэмэгдэж байна. Хани тогтворжих бүрэн нөхцөл бол бүрдээд явж байгаа учраас инфляц дээр ирэх бол дарамт бол байхгүй. Тэгэхээр өмнөх хани 2844-3540 болж 22 орчим хувиар унасан нь энэ нь өөрөө инфляцад бол нэлээд их хэмжээний нөлөө үзүүлсэн бас суурь нөлөөллийн нэг нь бол энэ хани байсан гэдгийг би бол хэлмээр байна. Тэгээд ерөнхийдөө саяын хэлэлцэгдсэн зүйлүүд бол хэвийн орж байгаа.*

*Хуримтлалыг бий болгох уу гэж байгаа. Яг энэ төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн төсөөллийг өргөн мэдүүлэхдээ одоо байгаа яг хуулийн хүрээндээ л бид нар өргөн мэдүүлсэн. Тэгэхээр түүн дээр хуримтлал үүсдэг ганцхан сан явж байгаа шүү дээ. Ирээдүй өв сан. Ирээдүй өв сан дээр тодорхой хэмжээний хуримтлалууд бол байгаа. 2023 онд бол ирээдүй өв санд бол 2,4 их наяд төгрөгийн орлого хуваарилагдаж байгаа. Тэгэхээр нийтдээ 2,4 их наяд гэж тооцож болно.*

*Тэр тэтгэврийн сан нэрийн дансанд шилжих тухай бас хэн Даваасүрэн ярьж байна. Тэтгэврийн нэрийн дансанд, өөрөөр хэлбэл хувь хүн өөрийнхөө нэр дээр дансаа шилжүүлдэг, түүнээсээ тэтгэврээ авч явдаг ийм тогтолцоо руу гээд бид нар хууль, эрх*

зүйн орчнуудыг нь тодорхой болгож байж дараагийн алхмууд бол хийгдэх юм.

**Г.Тэмүүлэн:** Хүрэлбаатар сайдын минутыг нэмье.

**Ч.Хүрэлбаатар:** Одоогийн өргөн мэдүүлсэн байгаа энэ тоонд бол одоогийнхоо хууль дээр нийцүүлээд өргөн мэдүүлчихсэн байгаа гэдгээ хэлье.

Өрийн хувьд бол энд Засгийн газрын энэ өрийн нийт хэмжээ гээд 24 онд 39, 25 онд 43, 26 онд 47 их наяд гээд тавьчихсан байгаа. Энэ нөгөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд байгаа хязгаар гээд тоо заачихсан байгаа шүү дээ. Яг тэр хязгаараараа тооцоод тооцоод тавьчихсан. Яг энэ бол хамгийн дээд хязгаар нь л гэж та бүгд ойлгож болно гэдгийг хэлье.

**Д.Даваасамбуу:** Засгийн газрын өөрийн асуудлаар Монгол Улсын Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс барьж байгаа зарчим бол арилжааны зээл буюу бондын зээлийг дахин санхүүжүүлэхдээ дор хаяж 20-30 хувийг нь төсвийн боломжоо ашиглаж төлж байх нь зүйтэй гэсэн зөвлөмж өгсөн. Үүнийг Жавхлан сайдын ярилцлагаас болон танилцуулгаас үзэхэд хэрэгжүүлээд явж байна гэж би ойлгосон. Ямар ч гэсэн 680 сая орчмыг бид төсвийнхөө боломжоос төллөө. Энэ хэмжээгээр, валютынх нь үнэлгээгээр би ярьж байна шүү. Валютынхаа үнэлгээгээр бондын маань зээлийн үлдэгдэл тодорхой хэмжээгээр багасаж яваа. Үнийн дүнгээрээ ханишийн 20 гаруй хувийн өсөлтөөрөө өсчихсөн байна лээ.

Дээрээс нь Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн өсөлт байгаа. Энэ 2-ыг бид байж болох байх гэж бодож байгаа. Тэр учраас энэ арилжааны зээлээс одоогийн нөхцөлд шууд татгалзахаас өөр аргагүй. Дэлхийд мөнгөний үнэ ихэдсэн гэж үзэж байгаа.

Мөн өрийн дэлхий нийтийн үнэлдэг 5 үзүүлэлтээс 3-ыг нь бид дээд хэмжээнд нь буюу анхаарал нэн хандуулах шаардлагатай гэсэн хэмжээнд байгаа. Энэ маань өөрөө нийт өрийн хэмжээ. Тэгэхээр бид төсвийн шинэчлэлийн талаар өргөн барьж байгаа хууль эдгээрт юуны өмнө бас өрөө багасгах, цаашидаа энэ үнэтэй зээлээс татгалзах гэдэг тал дээрээ байх байх.

Дээрээс нь Засгийн газрын хэвлэл мэдээллээр өгч байгаа мэдээллээс үзэхэд ер нь төсвийг цаашидаа төсвийн гүйцэтгэл, шалгуурт суурилсан үзүүлэлтүүдэд шилжүүлэх алхмыг хийнэ гэж ойлгож байгаа. Дэлхий нийтийн жишгийн дагуу салбарыг хариуцаж байгаа манай Эдийн засгийн яам маань бусад бүх яамдын төсвийн шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож, энэ үр дүнгээр нь ажлаа дүгнэх юм байна. Энэ маань өөрөө цаашидаа төсвийн хүрээний мэдэгдэл маань бас зардлын хязгаар, зардлыг гүйцэтгэлд суурилсан хувилбар луу орох нь. Энэ маань 2 жилийн өмнөөс эхэлсэн гэж би ойлгож байгаа. ЭМЯ дээр. Энэ жилээс Боловсролын яам дээр. Ингээд цаашидаа манай гол асуудлууд энэ юу гэвэл гүйцэтгэлд суурилсан, шалгуур үзүүлэлтэд суурилсан төсвийн төлөвлөлт, төсвийн хяналт тогтох нь гэдэг дээр бид энийг дэмжиж байгаа гэж ойлгож байгаа.

Дээрээс мэдээж манай эрсдэлтэй зүйл бол ихэнхдээ бид нарын тавьж та бүгдэд танилцуулсан материал, тэр нүүрсийг онцгойлон авч үзсэн байгаа. Бидний хүссэн хэмжээнд нүүрсээ гаргах уу, үгүй юу гэдэг дээр асар их ажиллагаа хэрэгтэй. Дээрээс нь бид өрсөлдөх чадвараа дээшлүүлэх шаардлагатай байх. 2022, 23, 24 оны Засгийн газрын ажлын үр дүн бол 1 дүгээрт, тэр төмөр замыг Гашуун сухайт, Тавантолгойг холбочихсон байх. Эрчим хүчний өнөөдрийн хэрэгцээг дор хаяж үйлдвэрлэлийг дор хаяж

20-30хувиар нэмэгдүүлсэн байх. Энэ л ажлын үр дүнгээр хэмждэг. Энэ маань өөрөө төсвийг тогтвортой болгох, төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд нэн чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа учраас энэ чиглэл рүү бид явна л гэж үзэж байгаа. Тийм учраас өрсөлдөх чадварыг дээшлүүлэх талаар ялангуяа нүүрсэн дээр онцгой анхаарч ажиллахыг бид санал болгож байгаа. Үнийн хувьд арай л... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Батжаргал гишүүн асуулт асууя.

**Ж.Батжаргал:** Төсвийн хүрээний мэдэгдэл төсөөлөл орж ирж байна. Тэгэхээр энэ бол эдийн засаг, төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн зохистой түвшний харьцаа юм. Тэгээд үүгээрээ дамжуулж бид нар эдийн засгийн өсөлт, амьжиргааны түвшинээ зөв авч явах тухай л бодлого л доо угаасаа. Тийм учраас үүн дээр бид нэлээн няхуур хандах ёстой гэж ингэж ойлгодог. Орлох орлого талаа бид мэдээж нэлээн нарийн тооцсон байх. Би дан дамаа биет хэмжээснүүдийн өсөлтийг нэлээн сайн зөв тооцсон байлгүй гэж ойлгоод байна л даа.

Оюутолгойн баяжмалаас бид нар 150 орчим мянган тонн гэж байгаа юм уу, энэ чинь? Тийм нэмэгдэхээр ийм л төсөөлөл харагдаж байгаа юм шиг байгаа юм. Үнийн асуудал нь нэлээн юутай.

Нүүрсэн дээрээ бид 36,5-тай явсан улсууд 50 гэхээр зэрэг 14 орчим сая тоннын өсөлттэй гээд ингээд авч. Тэгэхээр үүнийг нэлээн их бодитой дүгнэж байж бид нарын өнөө орлого тал буюу буцаагаад зарцуулах хөрөнгийн маань хэмжээний асуудал бол зөв гарч ирэх ёстой гэж. Үүнийгээ нэлээн нарийсгаж үзсэн байх гэж хараад байна.

Зардал талаа бид төсөөлж байна. Төсөөлөхдөө бас өсөлтийнхөө хувийг нэгэнтээ тооцсон бол тэр дотор энэ иргэдийн амьдралын чанарыг сайжруулахтай холбоотой зардлуудын ерөнхий төсөөлөл харагдах ёстой. Тийм учраас цалин, тэтгэвэр, тэтгэмжийн өсөлтийг бид ер нь хэд гэж багцаалдаж байгаа юм, 1.

2 дугаарт, дан ганц цалин тэтгэвэр 2-оор амьдралыг авч явахгүй нь ойлгомжтой. Үнэхээрийн л баялаг бүтээлтийг дэмжье гэж байгаа бол энэ хувийн хэвшил гэдэг юм уу баялаг бүтээгчдийг дэмжих хөрөнгийн талынхаа асуудлыг дотоодоосоо яаж хэдүүлээ дайчилна гэж харж энд ямар хэмжээний баримжаатай хөрөнгө юмнуудыг төсөөлж байгаа вэ гэдэг асуудал байгаад байна л даа. Жишээ нь бид нар 23 он дээр 220 хэдэн тэрбум төгрөг зээлийн хүүгийн зөрөөнд гээд тавьж байгаа явдал чинь бол баялаг бүтээгчдийг дэмжиж байгаа, зээлийг их наядад хүргэх гээд л зүтгэж яваа улс шүү дээ. Яг үүн шиг ер нь ийм эх үүсвэр талыг дэмжсэн юм хэдий хэмжээгээр тусаж орсон юм бэ гэдэг асуудал. Дараагийн нэг асуумаар байгаа зүйл байгаа юм. Энэ өр, тэнцлийн алдагдал 2-ыг бид их зөв харах ёстой. Дан дамаа тэнцлийн алдагдлыг бол бид 1,8-тай байх ёстой юмыг 1,5-тай ЗГ маань оруулж ирээд, Байнгын хороон дээр 1,4-тэй болгож бид 23 оны төсвөө баталсан. Тэгэхээр үүнийг Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлдэг хуулийн хувиар тооцож тавиад баймгүй байна, бодитой тавимаар байна. 24 оны төсөөллийг бид хэд гэж үзэх юм? Миний л ойлгож байгаагаар жоохон хариуцлагатай явцгаая, бас энэ нэг орлого, зарлагынхаа тэнцэл юмнуудыг зөв барьж, энэ улс орны хөгжлийн юмыг харж явъя гэж байгаа бол 0,8-аас нэг их давуулж тоо тавимгүй санагдаад байгаа. 24 оны тэнцлийн алдагдлыг.

Өр. Өрийн удирдлагын тухай хуулийн коэффициентээр бид тавьчхаад байгаа улс байхгүй юу. Бидэнд байж байгаа тоогоор 8,5 тэрбум долларын Засгийн газрын өртэй тухай ярьдаг. Дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувьтай тэнцэж болно гэж хэлээд 39



их наядаар аваачаад тавьчаад байгаа явдал чинь нийгмийг тэр чигт нь буруу мэдээлэлжүүлээд болж өгөхгүй байгаа юм. Одоо байгаа өр чинь яг хэд юм? 24 онд зайлиггүй энэ хөгжлийн хэрэгцээ шаардлага дээрээ уялдуулаад, зохицуулалт дээрээ уялдуулаад хэдий хэмжээний юм нэмж авах юм гэдэг юмаа тодорхой болгож тавимаар байгаа юм. Тэгж байж 56 хувь гэдэг юм уу 58 ...  
/минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайд асуултад хариулъя.

**Б.Жавхлан:** Тийм, Батжаргал гишүүний хэлж байгаа санаа зовж байгаа өнцөгтэй би ер нь бол санал нийлж байна. Гэхдээ бид нарын нөгөө нэг төсвөө төлөвлөдөг зарчим, төсвийн хүрээний мэдэгдлээ баталдаг зарчим маань ер нь бол хязгаараа батлах ёстой. Одоо саяын таны асуудаг цалин, зээлийн хүү, энэ өрийн хэмжээнүүд бол бид нар байгаа төсвийн шаардлагын хуулиуд дээрээ нарийн заачихсан. Жишээ нь тэр өрийн үлдэгдэл бол тэр хязгаараараа л явна. Өөрөөр хэлбэл бид нар энэ хязгаарыг хэтрүүлж болохгүй ээ л гэсэн үг. Хэтрүүлж болохгүй ээ гэсэн үг. 23 оныхоо төсвийг хийхдээ эндээ баригдаж орж ирэх л ёстой. Түүнээс эндээс хэтрүүлж болохгүй гэсэн үг. Цалин ч гэсэндээ хэдэн хувиар хэд орчим нэмэгдэхийг бас хэлэхэд арай эрт байна. Одоо бид нар наад энэ асуулт яг нөгөө төсөв өргөн бариад, төсвийнхөө зардлыг задалж ярихад л яригдах боломжтой ийм тоонууд.

Ямар ч байсан түрүүн таны асуудаг тэр зээлийн хүүгээр дамжуулж баялаг бүтээгчдийг дэмжих бодлого бол үргэлжилнэ. Ялангуяа хөдөө аж ахуйн салбар, үндэсний аюулгүй байдал, мөн ирэх жил сая ковидын үед эхлүүлсэн ажлын байрыг дэмжих зээлийн гарсан тэр зээлүүдийн сүүлийн жил нь. Тэгэхээр тэр энэ бодлого бол ингээд дуустлаа тууштай ингээд түүхэн үүргээ гүйцэтгээд явна. Тэгээд ямар ч байсан энэ оныхоосоо бодлогын хэмжээнд багасахгүй. Одоо удахгүй энэ чиглэлийн урсгал зардал авч явдаг төсвийн ерөнхийлөн захирагч нар, сайд нар маань саналуудаа оруулж ирнэ. Тэндээс бид 2,5 их наяддаа яаж нэмэгдлүүдийг нь багтаах вэ? Энэ жил гээд байхдаа хэвээр нь барих вэ гээд. Энэ бүх зүйлүүд яг төсвийн өмнөх өргөн барихын өмнөх, төлөвлөлтийн үед илүү их тодорхой болоод явна. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

**Ж.Батжаргал:** Тийм, хязгаар гэдгийг бол мэдээд байгаа. Гэхдээ хязгаар гэдэг бол зүүгээр коэффициентын нийлбэр биш л дээ. Ямар хэмжээний юмнуудын барагцааны хэлбэрийн дүн ийм гарах юм гэдэг юу ерөнхий төсөөлөл юм. Одоо бид нарт энэ 7 хоног өнгөрөөд, дараагийн 7 хоногт дахиад иргэдтэйгээ очоод уулзана. Бид төсвийн хүрээний мэдэгдлээ ярьж байгаа. Зардал маань 10 хэдэн хувиар өсгөж байгаа, тэр дотор ер нь энэ амьжиргаа дэмжихтэй холбоотой юм нь нэг тэдэн функц нь байгаа юм шүү гээд ярих л ёстой шүү дээ, бид. Тийм учраас тоо тодорхой байх ёстой. Үүнийг илүү задалмаар байна, мэдээлээ задалж өгмөөр байна. Тэгж байж бид нар энэ талынхаа асуудлыг зөв яримаар байна. 2024 оны хөгжлийн төлөвлөгөө үүнтэйгээ ерөнхий багцаагаараа бол анзаарагдаж уягдах ёстой. Гэтэл мухар төмөр замуудын Хангийн замын гүйцэтгэл 20 хувьтай л гэж байна, холболтын ажил. Юуны Гашиун сухайтынх нь.

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Тийм. Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдлийг бол бид хуулийн хүрээнд ерөөсөө энэ 9 макро тоон дээрээ л оруулж ирдэг юм байгаа юм. Энэ бол дан яг хязгаар, яг цаг хугацааны хувьд ч гэсэн одоо бид нар энийг задалж ярьж тайлагнах ийм боломжгүй.

Яамнууд төсвийн эргэлтэд захирагч нарт ч гэсэндээ тэд одоо ч төлөвлөж амжаагүй байгаа. Задалж төлөвлөж амжаагүй байгаа. 6, 7 сараас л эхний төлөвлөлтүүд гарч ирдэг, 6, 7 сараас л эхэлж Сангийн яаман дээр эхний 24 оны саналууд ирнэ. Тэр үед илүү задлах боломжтой, ярих.

Харин төсвийн хүрээний мэдэгдлүүдээ ингэж хязгааруудаа батлуулж аваад энэ хүрээндээ харин иргэн яаж төлөвлөх вэ гэдэг дараагийн ажилдаа төсвийн ерөнхийлөн захирагч нар маань ороод ингээд явна. Тийм.

**Г.Тэмүүлэн:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулж санал хэлэх гишүүд байна уу. Үг хэлэх гишүүд байна уу. Батжаргал гишүүнээр тасалъя.

**Ж.Батжаргал:** Хүрээний мэдэгдэл, төсөөллөө үзэл баримтлалынх нь хувьд бид дэмжих ёстой...

Дараа нь нэгэнт бий болчихсон жосоохон энэ үр дүнг, тэгээд дан дамаа энэ заяагдмал баялгийн үр өгөөжийн тодорхой хэсгийг хуримтлал болгох, тэр хуримтлалынх нь тодорхой хэсэг иргэдийнхээ нэр дээр хуримтлал болдог. Тэгээд тэр хуримтлал нь эргээд дотоодынхоо хөгжлийн том төслүүдийг гэдэг юм уу, хөгжлөө тэтгэсэн эх үүсвэр болж ашиглагддаг зах зээлийнх нь зарчимд нийцүүлэх эрх зүйн том шинэтгэлийг маш шуурхай хиймээр байгаа юм. Энд бага, ихийн тухай ойлголт байхгүй. Зарчим нь зөв явбал жилээс жилд наад яригдаж байгаа тоон үзүүлэлтүүд нэмэгдээд, тодорхой нэлээдгүй хэсэг маань хуримтлалтай болох, нэлээдгүй хугацааны ар дээр бүх нийтээрээ хуримтлалтай болох, дотоодоосоо хөгжлийнхөө эх үүсвэрийг дайчилж болдог тэр үйл явц руугаа шилжих нэлээн том хөгжлийн шинэ чиг хандлага байх ёстой гэж ингэж хараад байгаа.

Тийм учраас би Эдийн засгийн яамыг, Сангийн яамыг, Засгийн газрыг ер нь энэ тал руугаа хүрээнийхээ мэдэгдлийг батлуулж аваад л төсвийн боловсруулалтынхаа үйл явцтай давхар энэ чиглэлийн юмнуудаа тэмтэрч, эрх зүйн шинэ орчныхоо асуудал руу орох ёстой байх л гэсэн ийм байр суурьтай байна. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Гишүүд санал хэлж дууслаа.

Тэгэхээр бас хэд хэдэн асуудлууд бол Байнгын хороон дээр гишүүдийн хэлсэн асуулт, санал дээр давхцаж байна. Нэг талдаа би нэг чиглэлийг бас Засгийн газарт болоод Сангийн яаманд чиглэл болгох гэж байгаа. Нэг бол энэ Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолын дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зөвлөмжид ЗГ тайлбар ирүүлэх учиртай болсон байгаа. Тэгэхээр иймд маргааш Төсвийн хүрээний мэдэгдлийг Улсын Их Хурлаар хэлэлцэнэ. Тэгэхээр Засгийн газрын зүгээс маргаашийн чуулганы хуралдаанаар төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэхээс өмнө тайлбарыг ирүүлэх чиглэлийг та бүхэнд бас өгч байна, 1 дүгээрт.

2 дугаарт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Эдийн засгийн хөгжлийн яамнаас ирүүлсэн макро үзүүлэлтэд үндэслээд энэ төсвийн тэнцвэржүүлсэн орлогын тооцоог маргааш чуулганаар хэлэлцэхээс өмнө хуульд нийцүүлж хийсэн аргачлал, тооцооллыг задалж Төсвийн байнгын хороонд ирүүлэхийг бас та бүхэнд даалгавар болгож байна. Тэр дундаа алтны тооцоог нарийвчилж тооцож ирүүлэх чиглэлийг бас Байнгын хорооноос болгож байгаа гэдгийг та бүхэн бас анхаарч авч үзээрэй.

## **Хавсралт 8. Ярилцлагын тэмдэглэл**

### **Төсвийн тогтвортой байдлыг хангахад орон нутгийн төр захиргааны байгууллагын үүрэг, эрх хэмжээ, төсвөөс санхүүжүүлэх чиг үүрэг хэрэгжилтийн талаар хийсэн судалгааны ажлын талаар хийсэн ярилцлагын тэмдэглэл**

2023 оны 11 дүгээр сарын 03 -ны өдөр

Улаанбаатар хот

Ярилцлагыг Монгол банкны бодлогын зөвлөлийн ажлын өрөөнд Тогтвортой байдлын зөвлөлийн дарга Д.Даваасамбуу, ажлын албаны ажилтан Б.Одмандах, судалгаа хийсэн Монгол улсын иргэн Я.Онгойбор нарын бүрэлдэхүүнтэй хийлээ.

Ярилцсан нь:

**Д.Даваасамбуу:** Бид гэрээт ажил хийсэн Ядамжав овогтой Онгойбортой ярилцлага хийх гэж байна. Гэрээт ажил маань төсвийн тогтвортой байдлыг хангахад орон нутгийн төр захиргааны байгууллагын үүрэг, эрх хэмжээ, төсвөөс санхүүжүүлэх чиг үүрэг хэрэгжилтийн талаарх судалгааны ажлын дүнгийн тухай юм. Бид өнөөдөр судалгааны материалыг хүлээн авч акт үйлдэж байна. Мэргэжлийн хүний хувьд өөрөөс чинь тодруулах зүйл байна.

Та өөрийгөө танилцуулна уу

**Я.Онгойбор:** Намайг Ядамжавын Онгойбор гэдэг. Би 1981 онд Иркутскийн Улс ардын аж ахуйн дээд сургуулийг төгсөж ирээд Сүхбаатар аймгийн Санхүүгийн хэлтсийн даргаар 1989 оны хүртэл ажилласан. 1989-1991 онуудад аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга, 1991-1999 оныг хүртэл Монгол даатгал компани салбарын захирал, 1999-2004 он хүртэл Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст төсвийн мэргэжилтэн, 2007-2012 онуудад аймгийн татварын хэлтэст Хяналт шалгалтын тасгийн дарга хийж байгаад тэтгэвэртээ гарсан.

**Д.Даваасамбуу:** Өнөөдрийн түвшинд сумын төсөв, аймгийн төсөв гэдэг ямар ойлголттой байна.

**Я.Онгойбор:** Өнөөдрийн байдлаар сум гэхэд Сумын иргэдийн хурал, сумын Засаг даргын тамгын газар, сум хөгжүүлэх сан гэсэн хоёрхон байгууллагын төсөв байна.

Аймаг бол тавхан газар байна. Аймгийн Засаг даргын тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Санхүү аудитын газар, Байгаль орчны газар гэсэн дөрөв тавхан газар л байна.

**Д.Даваасамбуу:** Аймагт төсвөөс санхүүждэг хэдэн байгууллага байна вэ?

**Я.Онгойбор:** Аймагт төсвөөс санхүүждэг 30-д байгууллага байна.

**Д.Даваасамбуу:** Наадах чинь таны судалгааны хэддүгээр хуудсанд байна вэ?

**Я.Онгойбор:** 54 дүгээр хуудсанд байна.

**Д.Даваасамбуу:** Наад дотор чинь ороогүй байгууллагууд байгаа юу?

**Я.Онгойбор:** Байгаа. Цэргийн ангиуд, Онцгой байдлын газар, Монгол банк гэх мэт байгууллагууд ороогүй.

**Д.Даваасамбуу:** Наад байгууллагуудын чинь орон тоо нь байна уу.

**Я.Онгойбор:** Төсвөөс санхүүждэг эдгээр байгууллагууд 3577 хүн 2019 онд байсан юм байна. Өнөөдрийн байдлаар 3880 хүн болсон байна. Энэ нь 2019 оноос нэмэгдсэн байна. Нэмэгдэхдээ гүйцэтгэлээр санхүүждэг Боловсрол, Соёл, эрүүл мэндийн байгууллагуудад нэмэгдэж болно. Гэтэл Аймгийн иргэдийн хурлын орон тоо 5-р, Засаг даргын тамгын газар 20-р, Сумдын тамгын газрууд 28-р, иргэдийн хурал 20 хүнээр тус тус нэмэгдсэн байна.

**Д.Даваасамбуу:** Хэдэн онтой харьцуулсан юм?

**Я.Онгойбор:** 2019 онтой харьцуулсан.

**Д.Даваасамбуу:** Тэгж их нэмэгдсэн юм уу?

**Я.Онгойбор:** Миний бодлоор цаг үе өөр болчихсон, бүх юм онлайн болсон, Компьютер техник хэрэгсэл өргөн ашиглагддаг болсон, бүх материалууд сүлжээнд холбогдохсон учир зарим орон тоог хэмнэж болох юм байна гэж бодож байна. Жишээлбэл намайг аймгийн иргэдийн тэргүүлэгчдийн хурлын нарийн бичгийн даргаар ажиллаж байхад би ганцаараа орон тооны албан хаагч байсан. Тамгын газар иргэдийн хуралд үйлчилж асуудал боловсруулах, бичиг хэргийн асуудал гэх мэт бүх юмыг нь хариуцдаг байсан. Гэтэл өнөөгийн байдлаар аймгийн иргэдийн хурал орон тооны 20 хүнтэй болсон байна.

**Д.Даваасамбуу:** Энэ олон сумын болон аймгийн төсөвт байгууллага, аймгийн Засаг даргын тамгын газар, иргэдийн хурал ямар харилцаатай байдаг юм бэ?

**Я.Онгойбор:** Хуучин төсвийг цэргийн анги болон нууцлалтай төсөвтэй газруудаас бусад бүх байгууллагуудын төсвийг аймгийн ИТХ баталдаг байсан. Аймаг аймгийн төсвийг Сангийн яаманд, бусад дээрээ яамтай байгууллагуудын төсвийн тус тусынх нь яамдаар батлуулаад батлагдсан төсөв аймагт ирэнгүүт Аймгийн иргэдийн хурал тухайн төсвийг хэлэлцэн нэмэхийг нь нэмээд хасахыг нь хасаад байгууллагуудад хүргүүлдэг байсан. Энэ дагуу санхүүгийн тайлан нь мөн аймагт нэгтгэгддэг байсан. Тэр үед аймгийн дарга тухайн албан байгууллагуудын дарга нарыг томилдог байсан. Тиймдээ ч удирдлага зохион байгуулалт, төсвийн зохицуулалтаар хангаж ажилладаг байсан. Шаардлагатай тохиолдолд орон нутгаас нэмэлт төсөв олгодог байсан.

Одоо болохоор зөвхөн тогтмол зардлыг /гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус, урсгал засвар/ аймгийн төсвөөс олгодог, цалин болон бусад зардлыг улсын төсвөөс буюу тухайн яамдын төсвөөс нь гаргадаг болжээ.

**Д.Даваасамбуу:** Төсвийг 2 ангилж хийж өгөх юм уу? Тогтмол зардлыг нь аймагт, Цалин болон бусад зардлыг яам руу нь очиж батлуулж байна гэсэн үг үү?

**Я.Онгойбор:** Тийм. Энэ нь төсөв ерөнхийдөө хоёр эх үүсвэртэй болж байна гэсэн үг л дээ. Тэгэхээр орон нутаг яам хоёрын хооронд зөрчил гарч ирж байна. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нэг цэцэрлэг ноорхой байна уу, цоорхой байна уу тэрийг яамны мэргэжилтэн мэдэхгүй. Тэрийг орон нутаг мэдээд одоо энэ газарт засвар хийх шаардлагатай тул орон нутгийн төсөвт тавиад засварыг нь хийлгэе гэхээр одоо тийм юм байхгүй болсон байна.

**Д.Даваасамбуу:** Аймаг суманд байгаа төсөвт байгууллагуудад орон нутагт байхад зориулж гаргасан орон тоонд аймгийн тамгын газарт боловсрол, эрүүл мэнд, газрын

асуудал хариуцсан мэргэжилтнүүд байхаас гадна боловсролын газар, эрүүл мэндийн газар, газрын алба гэх мэт байгууллагууд байдаг. Тэгэхээр танай аймагт шинээр сургууль баригдлаа гэхэд тэрийг хэн хариуцаж хяналт тавих юм бэ?

**Я.Онгойбор:** Тухайн барилгад тухайн сумын сургууль, тамгын газар, аймагт боловсролын газар, тамгын газрын хариуцсан мэргэжилтнүүд ерөнхий хяналт тавьж Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын чиглэл чиглэлийн инженерүүд тухайн барилга угсралтын явцад хяналт хийж ажилладаг. Тэгэхдээ хуучин байдаг орон тоо маш их нэмэгдсэн байна. Тиймээс миний судалгааны дүгнэлтээс орон нутгийн эрх мэдлийг хасаад эрх мэдлийг төвлөрүүлчихсэн. Үүнээс болоод төрийн ажил цалгардах нөхцөл бий болж байна гэж гарсан. Мөн бүхэл бүтэн аймаг байж далан тэрбум төгрөгийн зардалтай байж түүний арван хоёрхон нь аймгийн төсөв байгаа байхгүй юу. Бусад нь дандаа төвлөрсөн төсөв байна.

**Д.Даваасамбуу:** Далан тэрбум төгрөгийн төсвийн аймгийн захиргаа бүх сумд нийлээд 12 тэрбум төгрөг байна уу?

**Я.Онгойбор:** Тийм. Аймгийн 12 тэрбум төгрөгийн төсөв дотор төсөвт байгууллагуудын тогтмол зардал орж байна. Тэгэхээр аймгийн төсөв маш бага хариугүй төсөвтэй байна гэж харж байна.

**Д.Даваасамбуу:** Энэ чинь бараг цалиндаа л явчихдаг юм биш үү?

**Я.Онгойбор:** Ерөөсөө л хэдэн хүний цалин гэсэн үг. Миний ойлголтоор орон нутагт төсвийн байгууллага л орон тоогоор хүнээ ажилтай байлгаж байна. Аж ахуй нэгж гэж манайд сүртэй том газрууд байхгүй. Улсын болон аймгийн үйлдвэрийн газрууд гэж байхгүй. Харин хувийн хэвшил нь ганц нэг хүнсний цех, дэлгүүр, мах боловсруулах жижиг үйлдвэр гээд л хязгаарлагдчихаж байгаа юм.

**Д.Даваасамбуу:** Эдгээр нь аймгийн төв дээр байна уу? хөдөө орон нутагт байна уу?

**Я.Онгойбор:** Аймгийн төв дээр ч байна. Хөдөө сумдад ч байна. Энэ газрууд мэдээ тоонд орохгүй байгаа. Ингээд харахад аймаг нь ерөөсөө эрх мэдэл байхгүй болсон юм байна.

**Д.Даваасамбуу:** Аймгийн дарга нар ажлын байр нэмэгдүүлэх боломж сонирхол байна уу?

**Я.Онгойбор:** Өөрт нь төсөв хөрөнгө байхгүй учир юугаараа ажлын байр бий болгох юм. Боломжгүй байна ш дээ.

**Д.Даваасамбуу:** Сумын засаг дарга мөн адил уу?

**Я.Онгойбор:** Мөн адил боломжгүй байна. Орон нутгийн хөгжлийн сан гэж бий л дээ. Тэр нь жил бүр ард иргэдээс санал авч хөрөнгө оруулалт хийнэ гэдэг. Ард иргэдийн санал бол тийм ч зөв шийдэл биш шүү дээ. Сум орон нутгийн хэтийн төлөвлөлтийг хийж түүнийгээ баримтлан жил бүр төсвөө зарцуулж байх нь зөв юм. Ард иргэд тэнд нэг халуун ус хэрэгтэй байна. Энд нэг талхны цех хэрэгтэй байна л гэнэ. Тэрийг нь бариад өгчихөөр нэг, хоёр жилдээ ажиллуулж байгаад дампууруулаад эвдэрхий балгас л болгочихдог нь сум орон нутгийг хөгжүүлэх нэн тэргүүний бодлого биш шүү дээ.

Санал асуулгаас харахад ажил огт хийхгүй байгаа юм алга дунд зэргийн л бүхэл асуудлууд нь дунд зэргийн нь л байна.

**Д.Даваасамбуу:** Ажил бол явж л байгаа байх

**Я.Онгойбор:** Явах нь ч явж л байна. Гэхдээ гойд сайн хийж байгаа юм бол алга. Орон нутгийн эрх мэдэл тийм их сайжирчихсан юм алга. Харин ч улам л хумигдаад байгаа шинж тэмдэг ажиглагдаж байна. Бодлогын яам бодлогоо хариуцаад гүйцэтгэлийг аймаг орон нутаг хариуцаад тэртэй тэргүй аймгийн Засаг дарга нар яамдуудтай гэрээ хийж ажилладаг. Тэрүүгээрээ үүрэг даалгавраа аваад тэр мөнгөөрөө ажлаа хийгээд явж болдоггүй нь ямар учиртай юм.

**Д.Даваасамбуу:** Өөрийн чинь дүгнэлтээс өөр юу анхаарал татаж байна.

**Я.Онгойбор:** Төсвийн хууль дүрмийг ойр ойр өөрчилж байна. Жишээ нь: 2019 онд аймгийн төсөвт байсан газар чинь 2023 онд улсын төсөв рүү яваад өгчихдөг юм байна.

**Д.Даваасамбуу:** Сүүлд соёл үлдчихсэн байсан.

**Я.Онгойбор:** Соёл ч мөн яам руугаа оччихсон. Тайлан мэдээ нь ч аймагт нэгтгэгддэггүй.

**Д.Даваасамбуу:** Засгийн газрын гишүүд л зардлаа хариуцах гэж тийшээ явуулаад байгаа юм биш үү.

**Я.Онгойбор:** Надад тэгж л харагдлаа. Тэр шинэ сэргэлтийн бодлого гэхэд яамнаас нь чиглэл өгдөг, хийдэг юм бол байгаа л байлгүй. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль нь орон нутгийн эрх мэдлийг дэмжсэн л гээд байгаа. Орон нутаг хийе гэхээр төсөв хөрөнгө байхгүй хийж чаддаггүй.

**Д.Даваасамбуу:** Би яагаад энэ судалгааг танаар хийлгэж байна вэ мэдэж байгаа байх та. Нэгдүгээрт, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар орон нутгийн эрхийг дэмжсэн гэж яриад байгаа.

Хоёрдугаарт, Одоогийн Засгийн газрын чиг бодлого нь орон нутгаа хөгжүүлж төвөөс хөдөө рүү гээд байгаа ш дээ тэгэхээр орон сууцны хөнгөлөлт үзүүлнэ гээд яриад байсан ш дээ тэгэхээр орон сууцны хөнгөлөлт үзүүлбэл төсвийн хэдэн байгууллагуудад ажиллаж байгаа хүмүүст л үзүүлнэ үү гэхээс биш хувийн хэвилийнхэнд яаж хөнгөлөлт үзүүлэх вэ л гэж асуугаад байна. Сүхбаатар аймаг байгалийн баялаг ихтэй яваандаа өөрөө бие даагаад өөрийнхөө орлогоор зарлагаа нөхөөд явах боломж бий байх гэж хараад байна.

**Я.Онгойбор:** Уул уурхайтайгаараа бол тийм боломж байна. Гэтэл уул уурхайн орлогыг бүгдийг нь төвлөрсөн төсөв рүү татчихсан ш дээ. Уул уурхайн орлого бол татварын цөөн орлого байдгийг улсын төвлөрсөн төсөв рүү татчихсан харин тухайн суманд гадаадын ажилчдын татвар л орж байгаа. Түүгээр л жаахан амь тариа залгуулж байна.

**Д.Даваасамбуу:** Төвлөрүүлэх нь зөв буруу юу гэдгийн та бид 2 хэлэхгүй. Төвлөрүүлэх болсон шалтгаан нь бодитой байх ёстой юунаас болж төвлөрүүлж байна гэж бодож байна вэ?

**Я.Онгойбор:** Тэрийг бол мэдэхгүй байна.

**Д.Даваасамбуу:** Сургуулийн захирлыг гэхэд сумын Засаг дарга томилдог мэргэжлийн бус улс төрчдөөс томилдог гэж яригддаг энэ талаар

**Я.Онгойбор:** Тэр бол шалгуур байж болно ш дээ. Сургуулийн захирлыг гэхэд ямар мэргэжлийн ямар хүн байх ёстой юм тэрэн дээр нь шалгуур үзүүлэлтийг нь нарийвчлан тогтоож өгч болно шүү дээ. Яагаад гэвэл сургуульд багшаар төдөөс доошгүй жил ажилласан эсвэл сургалтын байгууллагад төдөөс доошгүй жил ажилласан тийм мэргэжлийн тийм хүн байна гэж зааж өгөх юм бол мэргэжлийн бус хүнийг захирлаар тавиад байхгүй байх боломж бүрдэнэ.

**Д.Даваасамбуу:** Ний нуугүй ярихад суманд хэн ажлаа сайн хийж байна гэдгийг сумын засаг дарга мэдэх болохоос биш яамны сайд мэдэхгүй биз дээ. Тухайн нутагт байгаа ард түмэн мэдэх ёстой биз дээ. Тэгэхээр ард иргэдийн оролцоо хангагдаж байна уу үгүй юу гэдэг асуудал байна. Ямар хүн тавив тэр хүн нь ажлаа хэр хийв гэдгийг ард түмэн хянаж байгаа ш дээ.

**Я.Онгойбор:** Одоо бол намаараа сонгодог болоод удаж байна.

**Д.Даваасамбуу:** Тийм бол дээшээ татсан нь зөв юм байна.

**Я.Онгойбор:** Тэгэхээр заавал намаар мэргэжлийн бус хүн сонгодгийг болиулахын тулд эрх зүйн орчиндоо зохицуулалт хийгээд шалгуур үзүүлэлтийг нь боловсронгуй болгон орон нутгаасаа тавих нь зүйтэй. Яагаад тухайн газар ажиллаж байгаа багш хүн болж болохгүй гэж. Аймаг яам хоёр хамтарч томилдог байж болно шүү дээ.

**Д.Даваасамбуу:** Хуучин бол бид ийм хүн томилох гэж байна гэж бичиг явуулаад холбогдох яамдаас нь саналыг нь аваад иргэдийн хуралд танилцуулаад томилдог байсан.

**Я.Онгойбор:** Уул нь тийм байсан. Одоо хуулиар сургуулийн захирлыг боловсролын яам томилдог болох юм гэсэн.

**Д.Даваасамбуу:** Орон нутгийн төсвийн орлого бараг төсвийн байгууллагуудын ажилчдын цалингийн татвараас ихэвчлэн бүрддэг юм шиг байна.

**Я.Онгойбор:** Ер нь тийм байна. Орон нутгийн төсвийн орлогыг төсвийн байгууллагуудын ажилчдын цалингаас татаж байна. Тээврийн хэрэгслийн татвар, Хүн амын орлогын албан татвар, малын татвар гэх мэт татвараас бүрдэж байна. Малын албан татварыг авч байсныг гэнэт болиулаад хоёр гурван жилийн өмнөөс сэргээсэн чинь хүмүүс төлөхөө байчхаад байна шүү дээ.

**Д.Даваасамбуу:** Урьд нь авахгүй байсан учраас.

**Я.Онгойбор:** Тийм. Малчид татвараа төлөхгүй маш хүнд байна. Татвар гэдэг чинь цаанаа эдийн засгийн бодлоготой, эдийн засгийн утга агуулгатай байдаг юм. Малын татвар авснаар малын тоо толгойг хязгаарлана, гарч буй бүтээгдэхүүний ашиглалтыг сайжруулна түүнээс гадна бэлчээрийн ашиглалтыг сайжруулах үр дүнтэй юм байхгүй юу. Бэлчээрийн даац хүрэхгүй бол эдийн засгийн онолоор малын татварыг нэмэх шаардлагатай. Гэтэл малын татварыг нь огт авахгүй болгочихсон чинь одоогийн залуу малчид татвар төлнө гэдгийн мэддэг хүн байхгүй болсон.

**Д.Даваасамбуу:** Миний хувьд 2 зүйл дээр санаа зовдог юм. Өөрөөс чинь асууя. Нэгдүгээрт, Хүмүүс ажил хийхгүй байна гээд яриад байна. Малынхаа ашиг шимийг авахгүй байна. Арьс, шир, ноосны үнэ буусан байж магадгүй. Цагаан идээгээ бэлдэхээ байж.

Хоёрдугаарт, Суманд хүн амын маш их аюултай үзэгдэл болж байна. Энэ нь юу гэхээр эмэгтэйчүүд нь хот руу явчихсан. Хэдэн харчууд үлдсэн. Авгай олодохгүй байна гэж яриад байгаа энэ үнэн юм болов уу үгүй юу? Энэ үзэгдэл танайд байна уу?

Хуучин цагаан идээгээ боловсруулж, сургуулийн байрны төлбөрөө хийж байж сурдаг, байрандаа ордог байсан. Гэтэл одоо төрөөс хүүхдийг нь үнэгүй хоол өгч, үнэгүй байранд суулгаж байгаа болохоор хүмүүс ажил хийхгүй байна уу.

**Я.Онгойбор:** За тэрийг бол мэдэхгүй юм. Ер нь хүмүүс ажил хийх маш дургүй болсон. Барилгын туслах ажилтан, ногоо тарих туслах ажилтан, модны нүх ухах туслах ажилтан гээд маш олон ажилд цалин өндөр байгаа боловч хүн олодохгүй байна. Энэ нь хавтгайрсан халамжийн бодлоготой холбоотой байна. Жишээлбэл: Хүүхдийн мөнгө байна. Энэ нь олон хүүхэдтэй айл сардаа их мөнгө авч байгаа болохоор ажил хийх шаардлагагүй гэсэн үг шүү дээ. Малчид сүү саалиа ашиглахгүй байна гэдэг нь үнэн. Үнээгээ эхлээр тавиад хуурай сүүгээр цай сүүлээд ууж байна шүү дээ.

**Д.Даваасамбуу:** Би орлого олж байж хүүхдийнхээ мөнгийг, хувцас хунар, хоол хүнсээ авах ёстой шүү дээ. Гэтэл халамжаас мөнгө өгөөд байхаар бэлэнчлэх сэтгэлгээтэй болоод байна гэсэн үг үү?

**Я.Онгойбор:** Яг тийм. Тэртэй тэргүй мөнгө халамжаар өгч байгаа юм чинь ажил хийгээд яах юм гэсэн сэтгэхүй суучихсан байна.

**Д.Даваасамбуу:** Хүн амын харьцааны асуудал хүнд байна.

**Я.Онгойбор:** Тэр үнэн. Энэ эр юм чинь яахав тэртэй тэргүй цэрэгт яваад өөрийнхөө амийг аваад явчихна. Энэ муу охин минь ном эрдэмгүй бол хөдөө хэдэн малын дэлэн шувтарсан амьдрахад хэцүү болно гээд эмэгтэй хүүхдүүдээ дандаа сургуульд явуулаад байгаа байхгүй юу. Тэр сургуульд явсан эмэгтэй чинь эргэж нутагтаа очно гэж байхгүй. Очсон ч гэсэн дээд боловсролтой болчихсон хотжсон хүүхнүүд чинь хөдөөгийн эрчүүдээ голоод байна. Орон нутагт хүнээ шингээдэг газрууд чинь төсвийн хэдхэн байгууллага. Тэр орон тоо нь хязгаартай. Үйлдвэр аж ахуйн томоохон газрууд байхгүй. Уул уурхайд болохоор голцуу эрэгтэй нөгөө мэргэжилтэй, мэргэжилгүй улсууд чинь очоод ажилладаг. Голдуу гадны хүмүүс очоод ажилладаг болчихоод байна л даа.

**Д.Даваасамбуу:** Ахиад нэг юм асууя. Хүүхдийн 5-10 насанд сурсан юм насаар нь тогтдог гэж яриад байна. Тэр үнэн юм болов уу? Малчдын хүүхдүүдийг 6 наснаас нь сургуульд сургаад байгаа нь яваандаа малчингүй болж мал маллах мэргэжлийн боловсон хүчингүй болох гэж байгаа юм биш биз дээ. Би бол малчин 5-10 насандаа мал маллах дөр суудаг байх гэж боддог. Тиймээс сургуульд 6 наснаас биш 8 наснаас малчны хүүхдийг авч болдоггүй юм болов уу гэж бодоод явдаг ш дээ.

**Я.Онгойбор:** Үнэхээр санал нэг байна. 6 настай хүүхэд чинь биеэ аваад явчхаж чадахгүй болохоор нөгөө малчны чинь эхнэр нь хүүхдээ аваад суман дээр суучихдаг. Хорь гучин настай залуу ганцаараа мал дээрээ байна. Тэгэхээр чинь өдөр малдаа яваад ирнэ хүйтэн гэр угтана, орой малдаа явж ирээд хөлдүү махаа гаргаад хоолоо өөрөө хийнэ гэдэг чинь ямар л олиг байх вэ. Тэгэхээр тэд малаас залхаж байна. Миний бодлоор бол хуучин найман настай хүүхдийг сургуульд авч байснаараа авах нь зүйтэй гэж бодож байна. Зургааг бодвол найман настай хүүхэд гэдэг чинь нэлээн том болчихсон, нэлээн бодолтой болчихсон, тодорхой хэмжээний амьдралын дөртэй болчихсон, өөрөө өөрийгөө дотуур байранд аваад явчих чадвартай болчихсон хүүхэд байдаг байхгүй юу.



**Д.Даваасамбуу:** Миний бодлоор малчны хүүхдийг хохироож болохгүй л дээ. Манай үндсэн хуулиар суурь боловсролыг үнэгүй олгох ёстой. Миний бодлоор 4-р ангиас сургуулиас гарсан хүмүүс сайн малчин болоод байна. За яахав бүрэн дунд юм уу дээд мэргэжил эзэмшинэ гэвэл тэр болно. 4-р ангиас гарсан хүүхдүүдийг алсын зайн сургалт юм уу эсвэл зундаа явуулын сургалтад хамруулж болно.

**Я.Онгойбор:** Тэр болно. Зайны сургалтын анги гэж байдаг. Тэр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд голчлон чиглэдэг. Дээхэн үед Залуу малчны сургууль гэж байсан шүү дээ.

**Д.Даваасамбуу:** Ер нь Төсвийн тогтвортой байдлын байгууллага гэж бий. Төсвийг орлоготой байлгахын тулд хүмүүс нь орлоготой байх ёстой. Орон нутагт байгаа хүмүүсийн орлого нь малын ашиг шимээсээ орох ёстой. Үүнээс хувь хүн өөрөө орлого олох ёстой. Үүнээс нь татвар авч байвал төсвийн суурь сайжирна. Орон нутагтаа байгаа аж ахуйгаа эрхлэх эрхийг нь сумын засаг дарга, хурал нь хийгээч ээ. Сум бүрийг ногоон тэжээл тарих шаардлагатай. Яагаад гэвэл махны, сүүний чиглэлээр үхрийн аж ахуй эрхлэхэд малдаа өгөх ногоон тэжээлтэй байх ёстой. Тэр ногоон тэжээлийн аж ахуйн ажилд 8, 9-р ангийн хүүхдүүдийг оролцуулдаг байх ёстой.

**Б.Одмандах:** Таны бодлоор Сүхбаатар аймгийн хувьд төрийн байгууллага биш, хувийн байгууллагууд ямар төрлийн үйл ажиллагаа явуулбал орлого олох, хүмүүс нь ажилтай болох боломж байна гэж харж байна вэ?

**Я.Онгойбор:** Манай аймгийн хувьд хамгийн түрүүнд малын түүхий эдийг боловсруулах хэрэгтэй байна. Ядаж хагас ч гэсэн боловсруулах шаардлагатай. Манай аймгийн хувьд малын арьс, шир, түүхий эд, малын гэдэс дотрыг хаяж байна. Энэ нь байгаль орчныг бохирдуулж байгаа бас нэг хэлбэр болж байна. Тэгэхээр тэрийг боловсруулдаг үйлдвэр хэрэгтэй байна. Анхан шатны боловсруулах үйлдвэр байвал хаяж байснаас тэр үйлдвэртээ хямдхан ч гэсэн таван цаасаар өгчихөд аль алиндаа орлого оруулна шүү дээ.

Мөн аймаг орны хувьд хүнсний нэг томоохон үйлдвэр хэрэгтэй байна. Энэ үйлдвэр нь дэргэдээ лабораторитой, стандарттай, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хэрэглэгчдээ хангадаг байх шаардлагатай. Одоогийн нөхцөлд хувь хүмүүс, жижиг цехүүд талх, нарийн боов хийж байна. Эрүүл ахуйн шаардлага хангасан, баталгаатай бүтээгдэхүүн гарч байгаа гэдэг маш их эргэлзээтэй байдаг.

Энэ уурхайнуудыг орон нутагт нь өгмөөр байгаа юм. Наадуул чинь том ш дээ. Орон нутагт удирдагдахгүй шүү.

Орон нутгийн орлого олох боломжтой томоохон хэсгүүдийг нь төвлөрсөн төсөвт авчихаар чинь орон нутаг байнгын татаастай л байна шүү дээ. Сүхбаатар аймаг өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг болсон шүү дээ. Тэр нь ч амжилттай болж илүү гарсан орлогоо улсын нэгдсэн төсөв рүү явуулдаг байлаа тэрийг нь улсын төсөв рүү авчихсан. Одоо улсаас татаас авдаг аймаг болсон. Татаас авдаг газрууд өөрийн орлогыг ахиу авна гэж боддоггүй шүү. Өөрөө орлого олдог орлогоороо үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг аймгууд бол орлогоо ахиу олохыг боддог байхгүй юу.

**Д.Даваасамбуу:** Татаас авдаг ихэнх аймгууд бүх орлогоороо зарлагаа нөхнө гэж байхгүй л дээ. Тэгэхээр нэг л зарчмыг хэлмээр байгаа юм. Танд 20 сая төгрөгийн татаас өгье. Бусдыг нь та орлого олоод нэмээд байгаарай татаасаа хэмнэвэл танд үлдээнэ шүү гэвэл орлогоо ч нэмнэ, зардлаа ч хэмнэнэ гэсэн зарчмаар л явах ёстой. Орлогоороо зарлагаа нөхөх үе шат гэж байгаа. Ингэж чадвал дороо л босоод ирнэ гэж ярьдаг нь үнэн болов уу

**Я.Онгойбор:** Тэгвэл босно шүү.

**Д.Даваасамбуу:** За за ингээд ярилцлагаа дуусгая.